ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-24
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	25-72
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	25-26
2.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2024.09.27-ны өдөр ирүүлсэн/	26-48
3.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	48-72

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 16-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 18 минутад Төрийн ордны "Их эзэн Чингис хаан" танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, М.Мандхай, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Цэнгүүн;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Б.Жаргалан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл */Цаглавар батлах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж "Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай" Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Р.Сэддорж: "Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай" Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр."Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Монголбанк 2024.09.27-ны өдөр ирүүлсэн/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай, Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, О.Батнайрамдал, Э.Батшугар, Г.Лувсанжамц, Л.Соронзонболд, Б.Найдалаа, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3 дахь бүлэгт доор дурдсан агуулгатай шинэ заалт нэмэх:

“3.5.Гар утсанд суурилсан төлбөрийн картын болон олон улсын цахим худалдааны системүүдийг Монгол Улсад амжилттай нэвтрүүлэх хүрээнд банк санхүүгийн байгууллагыг дэмжиж ажиллах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 14
Бүгд: 16
12.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 4 дүгээр бүлэг шинээр нэмэх:

“**4 дүгээр бүлэг.Орон нутаг дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд**

4.1.Орон нутагт олгосон бизнесийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг бууруулах;

4.2.Орон нутагт бизнесийн зээл болон хэрэглээний зээлийн зохистой харьцааг боловсруулж, арилжааны банкаар мөрдүүлэх;

4.3.Орон нутаг дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгож байгаа зээлийн хүүгийн хувь хэрэглээний зээлийн хүүгээс бага байх бодлогыг хэрэгжүүлэх;

4.4.Зээлийн батлан даалтын сангийн баталгаа, зээлийн даатгалын болон бусад хэлбэрээр орон нутагт бизнес эрхлэгчдийн бизнесийн зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулахад дэмжлэг үзүүлэх бодлогын арга хэмжээ авах;

4.5.Бизнесийн зээлийн үйл ажиллагааны үе шат бүрийг 100 хувь дижитал шилжилт хийсэн тохиолдолд эрсдэлээр жигнэх хувийг бууруулах болон бусад бодлогын арга хэрэгслээр дэмжих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн газрын зөвлөх Б.Манлай, О.Сүлд-Өрлөг, ахлах шинжээч Х.Оюунцэцэг, ахлах мэргэжилтэн З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга

бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа сайд нарын ирцтэй холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал тайлбар хийв.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6

Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид "Ажлын хэсэг" гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.52 дахь заалтын "төлөвлөлтийг баталж," гэсний дараа "идэвхтэй болон идэвх багатай улирлаар ялгаатай бодлого" гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтын "бизнесийн орчин," гэсний дараа "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ" гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.16 дахь заалтын "бэрхшээлийг арилгах," гэсний дараа "хүний нөөцийн тулгамдсан асуудлыг гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлогоор дэмжиж, шаардлагатай" гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.18, 1.3.19, 1.3.20 дахь заалт нэмэх:

"1.3.18.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгааны ажлыг зохион байгуулна.

1.3.19.Бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, тухайлсан салбаруудын татварын ачааллыг бууруулах бодлогыг боловсруулж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

1.3.20.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх чиглэлд хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

"4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын "Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг соёрхон батлуулах арга хэмжээний хэрэгжилт" гэсний "Суурь түвшин"-ний "-" гэснийг "10" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2.1 дэх дэд заалтын "Гоц халдварт өвчний голомт" гэсний "Суурь түвшин"-ний "100" гэснийг "128" гэж, 1.2.3.1 дэх дэд заалтын "бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт төслийг үргэлжлүүлэх" гэснийг "дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх" гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.3 дахь дэд заалтын “төслийг хэрэгжүүлэх” гэсний дараа “/Дарханы арьс ширний цогцолбор болон бусад/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “15” гэснийг “30” гэж, “Зорилтот түвшин”-ний “20” гэснийг “55” гэж, 1.5.2.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “60” гэж, 1.5.2.6 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “30” гэснийг “20” гэж, 1.5.2.8 дахь дэд заалтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Бусад эх үүсвэр” гэснийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, 1.5.2.12, 1.5.2.13 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “75” гэснийг “35” гэж, 1.5.2.15 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж, 1.5.2.16 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “40” гэж, 1.5.2.18 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “50” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтад холбогдох мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.4.Эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх үндсэн бичиг баримт болох нэгдсэн сүлжээний дүрэм, түүнтэй холбоотой менежментийн тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нэгдсэн сүлжээний дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Бусад эх үүсвэр” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.1.4 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “69” гэж, 1.8.3.2 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “40” гэж, 1.8.3.4 дэх дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “70” гэснийг “30” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6 км авто зам барих,” гэж, “Суурь түвшин”-д “50” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “34.927,9” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж мөр тус бүр харгалзуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.12.1.1 дэх дэд заалтын “GIS,” гэснийг “газар зүйн мэдээллийн систем,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 17.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “2.1.2.7.Хөвсгөл аймагт “Хөх баавгайн үүр” төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилт”-д “3,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 18.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “2.1.2.7.Хөвсгөл аймагт “Хөх баавгайн үүр” төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилт”-д “3,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1.8 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “720” гэснийг “240” гэж, 2.3.1.10 дахь дэд заалтын “Санхүүжилт”-ийн “200,000.0” гэснийг “165,000.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.1.1 дэх дэд заалтын “Шинээр байгуулах нийгмийн эрүүл мэндийн төв”-д харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.11 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “90” гэснийг “0” гэж, 3.1.5.1 дэх дэд заалтын “Зорилтот

түвшин”-ний “>150” гэснийг “100” гэж, 3.2.1.1 дэх дэд заалтын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн барилга шинээр барих, ашиглалтад оруулах” гэснийг “Стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулах” гэж, мөн дэд заалтын “Ашиглалтад орох цэцэрлэг”-ийн “Суурь түвшин”-ний “34” гэснийг “35” гэж, мөн дэд заалтын “Шинээр баригдах цэцэрлэг” гэснийг “Цэцэрлэгийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “27” гэснийг “28” гэж, “Санхүүжилт”-ийн “35,616.1” гэснийг “38,189.4” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.1.2.13.Улаанбаатар хотод 2 дугаар шатны эрүүл мэндийн төвийг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “13,500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.4 дэх дэд заалтын “Ашиглалтад орох сургууль”-ийн Зорилтот түвшин”-ний “25” гэснийг “26” гэж, “Шинээр барих сургууль” гэснийг “Сургуулийн шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “53” гэснийг “0” гэж, “Зорилтот түвшин”-ний “36” гэснийг “41” гэж, “Санхүүжилт”-ийн “121,152.8” гэснийг “135,005.7” гэж, мөн заалтын “Шинээр барих дотуур байр” гэснийг “Дотуур байрны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “15” гэснийг “0” гэж, “Санхүүжилт”-ийн “21,734.9” гэснийг “25,414.8” гэж, мөн заалтын “Шинээр барих спорт заал” гэснийг “Спорт заалны шилжих барилга” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “0” гэж, 3.2.1.7 дахь дэд заалтын “Суурь түвшин”-ний “25,000” гэснийг “30.3” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.9 дэх дэд заалтад харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.4.1.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “23.7” гэж, 3.4.2.1 дэх дэд заалтын “Суурь түвшин”-ний “-” гэснийг “14.2” гэж, 3.5.1.3 дахь дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.09” гэж, “Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.5” гэж, 3.5.1.4 дэх дэд заалтын “Арга хэмжээний хэрэгжилт” гэснийг “Мян.хүн” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “1.43” гэж, Зорилтот түвшин”-ний “100” гэснийг “2.0 гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.5.1.5.Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн дэмжих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “8,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1 дэх заалтын “Зэвсэгт хүчний” гэсний дараа “үүрэг” гэж нэмж, 4.6.1.7 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “3” “гэснийг “2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Шууд хөрөнгө оруулалт” гэснийг “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Тэргүүлэх чиглэлийн үр дүн”-ийн 3 дахь заалтын “Үндэсний статистикийн хороо” гэснийг “Нэгдсэн Үндэстний Байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-гийн 1.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “2.8” гэснийг “3.5” гэж, 1.9 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.2 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “11-13” гэснийг “12” гэж тус тус өөрчилж, 1.10 дахь заалтад харгалзах мөр тус бүрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.1 дэх заалтын “Зүрх судасны өвчин, хорт хавдрын өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/”-нд харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо” гэснийг “Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /30-70 нас/” гэж, “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “973.9” гэснийг “41.8” гэж, “Зорилтот түвшин” “779.1” гэснийг “41.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж /Монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/”, “Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж” гэсэн шалгуур үзүүлэлтийн “Мэдээлэл цуглуулах давтамж”-д харгалзах мөр тус бүрийн “Жилд нэг удаа” гэснийг “Гурван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж”-д харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшсэн 18 настай хүн ам”-ын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “77.1” гэснийг “81” гэж, “Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг”-ийн “Суурь он”-ны “2021”

гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “60” гэснийг “48.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “66” гэснийг “50” гэж, “Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “71” гэснийг “50.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “76” гэснийг “52” гэж, 3.3 дахь заалтын “Хүүхдийн эрхийн индекс”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 3.8 дахь заалтын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 4.2 дахь заалтын “Суурь он”-ны “2017” гэснийг “2019” гэж, “Суурь түвшин”-ний “63.1” гэснийг “64.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”- ийн 1.1.2 дахь заалтын “хөрөнгийн өгөөж /ROA/” гэсний дараа “, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж нэмж, “Зорилтот түвшин”-ний “4” гэснийг “77” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, Суурь түвшин”-ний “2.5” гэснийг “3.5” гэж, 1.4.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” “гэж, “Суурь түвшин”-ны “50” гэснийг “229” гэж, “Хүрэх түвшин”-ний “100” гэснийг “200” гэж, 1.7.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “20” гэснийг “40” гэж, 1.8.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “2” гэж, мөн заалтын “Мэдээллийн эх сурвалж”-ийн “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэснийг “Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж, 1.9.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний ”13“ гэснийг “17.8” гэж, 1.10.1 дэх заалтын “Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ”-ний “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “10” гэснийг “17” гэж, “Зорилтот түвшин”-ний “15” гэснийг “19” гэж, “Дахин хог хаягдлын эзлэх хувь”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “15.7” гэснийг “21.1”, “Зорилтот түвшин”-ний “19” гэснийг “27” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”- ийн 1.11.2 дахь заалтын “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” гэснийг “Ашиглалтад өртөмтгий ургамлын ашиглалтын нөөцийг тогтоож, амьтны ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ” гэж, “Ургамлын зүйл”-ийн “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “7702” гэснийг “5” гэж, “Зорилтот түвшин”-ний “7702” гэснийг “2” гэж, мөн заалтын “Амьтны зүйл” гэснийг “Сэргээн болгон сэлгэн нутагшуулсан амьтны зүйл” гэж, “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “756” гэснийг “7”, “Зорилтот түвшин”-ний “756” гэснийг “7” гэж, 1.11.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Зорилтот түвшин”-ний “10” гэснийг “5” гэж, 1.11.4 дэх заалтын “Мэдээллийн цуглуулах давтамж”-ийн “Жилд нэг удаа” гэснийг “Таван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 4.2.1 дэх заалтын “Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “21” гэснийг “20” гэж, мөн заалтын “Давтан шинжилгээ”-ний “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “549” гэснийг “916” гэж, “Зорилтот түвшин”-ний “440” гэснийг “800” гэж, 4.3.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “76.5” гэснийг “78.4” гэж, 4.6.2 дахь заалтын “Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газар”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “12”, “Зорилтот түвшин”-ний “6” гэснийг “10” гэж, мөн заалтын “Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэг”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “5” гэснийг “6” гэж, мөн заалтын “Хөрсний чанарын стандартаас давсан бохирдолтой цэгийн тоо”-ны “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Р.Сэддорж: Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн бүтэц, нэр томьёо, найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх эрхийг олгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Р.Сэддорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.9.бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.3.7.Дархан-Уул аймагт малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах болон дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн цогцолбор байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Дэд бүтцийн бүтээн байгуулалт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Санхүүжилт”-д “100,000.0” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.6.Хөдөө, аж ахуйн /газар тариалан/ гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, боловсруулалтын түвшинг ахиулах төслийг орон нутагт хэрэгжүүлэх /Төв, Дархан, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “9,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.3.1.7.Дунд хоршооны хөгжлийг дэмжих газар тариалангийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хадгалах зоорь байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “5,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.4.1.3.Уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, сонгон шалгаруулалтын программ, техник хангамжийг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “80” гэж, “Санхүүжилт”-д “15,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын “Бодлогын үндэслэл”-д “МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.2” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж, мөн заалтын “Бодлогын үндэслэл”-д “ МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.4” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг ашиглалтад оруулж байнгын ажиллагаатай боомт болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.5.2.21.Мандал сумаас Түнхэл тосгон хүртэлх 35 км хатуу хучилттай замын төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “16,250.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “1.5.2.22.Улаан-Уул, Баянзүрх, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдыг холбосон гүүрэн байгууламжийг шинэчлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.1.5.Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Нам хүчдэлийн стандартыг шинэчлэн боловсруулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Санхүүжилт”-д “600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”- д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “99,820.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 11.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”- д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “99,820.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 11.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”- д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “99,820.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 12.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 12.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 9
Бүгд: 13
30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Даланзадгадад 50МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн бэлтгэл ажлын явц” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “405,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.23.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.24.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалгын ажлыг оршин суугчдын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “3.2.1.11.Халаалтын урсгал

зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэж, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн, сургалтын байгууллагын тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “10” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “500.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн дэд заалтын “Шалгуур үзүүлэлт”-д “Пассив барилгын шаардлагад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий сургууль, цэцэрлэгийн нэг маягийн барилгын зураг төсөв” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-нд “0” гэж, “Зорилтот түвшин”-д “5” гэж, “Санхүүжилт”-д “400.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Боловсролын яам” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.14 дэх дэд заалтын “хяналтыг боловсронгуй болгох” гэснийг “хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 1.8 дахь хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-ийн “Хүлээн авах” гэсний дараа “Идэвхтэй улиралд хүлээн авах” гэж нэмж, мөн хэсгийн “Суурь түвшин”-ний “0.6” гэснийг “0.38” гэж, “Зорилтот түвшин”-ний “1.5” гэснийг “0.9” гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн “Шалгуур үзүүлэлт”-д “Идэвх сул улиралд хүлээн авах гадаад жуулчид” гэж, “Суурь түвшин”-нд “0.22” гэж, “Зорилтот түвшин”-д “0.6” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа хуралдаанаар санал хураалгаж дэмжигдсэн ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналуудтай давхардсан тул 2 зарчмын зөрүүтэй саналаа татаж авав.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.9.бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн хуралдаанаар санал хураалгаж дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналаа хүчингүй болгох горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан шинэ заалт оруулах:

“1.3.10.Бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Р.Сэддорж: 18.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан шинэ заалт оруулах:

“1.3.10.Бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон "Их эзэн Чингис хаан" танхим
13 цаг 18 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: *Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Байнгын хорооны хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ амгаланг айлтгая.*

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Бямбасүрэн гишүүн орон нутагт томилолттой, Мандухай гишүүн гадаадад томилолттой, Цэнгүүн гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Энхтүвшин гишүүн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын өөрийг нь оронд нь томилох хүн яригдсан хурал болж байгаа учраас чөлөө хүссэн байна. Ингээд ирц 52 хувьтай байгаа учраас ирцийг танилцуулж дуусла. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. 2.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монголбанк 9 сарын 27-ны өдөр ирүүлсэн. 3.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл ЗГ-аас 9 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудлын дараалалд оруулах саналтай гишүүд байна уу? Энхцэцэг гишүүн сая бид нар нөгөө бас энэний өмнө уулзаж байсан. Тэгээд тийм юутай юм уу? Даргын зөвлөлийн хурлаар батлсан дараалыг өөрчилж болохгүй гэсэн ийм, горимын саналаар хойшлуулж болох юм байна. Дараалалд өөрчлөлт оруулах бол боломжгүй гэж энэ ажлын албанаас хэлж байна. Ажилтай байгаад байгаа юм байна давхар. Тэгээд байгаа юм байна. Нэмж болох биз дээ хэлэлцэх асуудалд. Лувсанжамц гишүүн. Бас нэг нэмэх гэж байсан юм бид хэд бас нэг энэний өмнө бас нэг кофе уусан юм. Нэмэх боломжгүй юм байна. Дараалал өөрчлөх боломжгүй байдаг юм байна, нэмэх боломжгүй байдаг юм байна.

Тэгээд санал гэж ямар санал авах юм бэ? Хойшлуулах эсэх талаар л санал байгаа юм, юу авах юм байна. Ингээд дараалал өөрчлөх болон нэмэх, хэлэлцэх асуудал дээр нэмэх бол санал авах боломжгүй юм байна. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд алга байна. Зөв, зөв. Тэгээд хуралд бэлэн болоогүй амжаагүй асуудал бол байхгүй юм байна. Хэдүүлээ бүгдээрээ олон санал хураалт байгаа учраас тэгээд боломжоороо 25 хүнээсээ ирүүлээд 3 хүнээс бусад нь бол ирэх боломжтой л харагдаж байна. Гадаадад 1 томилолттой, эмнэлгийн, орон нутгийн 2 хүнтэй. Тэгэхээр 23 гишүүн ирэх боломжтой л гэсэн үг. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол,

Улаанбаатар хот. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 163 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороонд хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил, арга зүйн зохион байгуулалттай туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт үүрэг болгосугай. Эдийн засгийн байнгын хорооны дарга гэсэн ийм тогтоолын төсөл байна. Хавсралт нь байгаа юм уу? Тараачихсан байгаа юм байна хавсралт нь.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалт. Тогтоолын төслийг санал хураалт Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 84,6 хувиар дэмжигдлээ. Энэ протоколд энэ миний хурууны хээ ерөөсөө уншигдахгүй байгаа юм, дэмжсэнээр оруулахыг хүсэж байна. Санал хураалт дуусла.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дуусла.

13.25 цаг

***Хоёр.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл** /Монголбанк 2024.09.27-ны өдөр ирүүлсэн/*

Дараагийн асуудалд оръё. Ажлын хэсгийг оруулъя. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн, Монголбанкны ерөнхий эдийн засагч Доожавын Ган-Очир, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Баярсайханы Баярдаваа, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт бодлогын газрын захирал Найманжингийн Ариунбат, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Дүнхүүгийн Аюуш, Монголбанкны Судалгаа статистикийн газрын захирал Дамдинжавын Даваасүх, Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Цэдэвсүрэнгийн

Нарандалай, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал Пүрэвдоржийн Мөнхбаяр. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна. Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофоныг нээе 5 номер.

Б.Лхагвасүрэн: *Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье. Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Цар тахлаас эхлэн геополитикийн хурцадмал байдлаар даамжирсан хүндрэлийг Монгол Улс амжилттай даван туулж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн зах зээл сүүлийн 2 жилийн хугацаанд бүрэн сэргээд байна. Цаашид эдийн засагт гарч буй эерэг үр дүнг бэхжүүлж, эдийн засгийн сэргэлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалахад чиглэсэн төсөв мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал байна гэж Монголбанкны зүгээс харж байгаа.*

Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, эдийн засаг эхний хагас жилд 5,6 хувиар өслөө. Цалин, тэтгэвэр зэрэг өрхийн орлогын өсөлтийг дагаад хувийн хэрэглээ тэлж, нийт эрэлтийг бас дэмжсэн байна. Өнгөрсөн өвөл тохиосон зудын улмаас хөдөө аж ахуйн салбар оны эхний хагаст 26,7 хувиар ахисан хэдий ч бусад салбарт өсөлтийн эрч сайн байна. Уул уурхай ХАА-гаас бусад салбарын үйлдвэрлэл эхний хагас жилд 10,3 хувиар өслөө. Монголбанкны төсөөллөөр эдийн засгийн өсөлт энэ онд 5-6 хувьд хадгалагдаж, ирэх онд төсвийн тэлэх бодлого Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжих зэрэг нөлөөгөөр эдийн засаг 7-гоос 8 хувиар өсөхөөр бас хүлээгдэж байна. Инфляцыг бууруулж, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогынхоо арга хэмжээ үр дүнгээ өгч, инфляц сүүлийн 5 сарын турш зорилтын орчимд тогтвортой хадгалагдаж байна. Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, төсвийн төлөв сулрах, гадаад инфляц өсөх зэргээс шалтгаалан ирэх онд инфляц нэмэгдэх хэдий ч зорилтын дээд интервалд хадгалагдах хүлээлттэй байна.

Ирэх оны төлөвлөсөн бүтээн байгуулалтыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай байгаа. Дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх нь эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэр алдагдах, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш, инфляцад дарамт нэмэгдэх эрсдэлтэйг бас онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Иймээс инфляцыг зорилтод хадгалах, мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлж, нийлүүлэлтийн доголдол үүсэхгүй байхад анхаарч ажиллах нь чухал байх гэж Монголбанкны зүгээс харж байгаа.

Гадаад эрэлтийн таатай нөхцөл байдал үргэлжилж экспортын орлого нэмэгдэж байна. Үүний үр дүнд гадаад валютын нөөц энэ оны 3 дугаар сард түүхэн дээд түвшин болох 5,2 тэрбум долларт хүрч өссөнөөр Монголбанк Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 50 хувийг төлж барагдууллаа. Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцийн эерэг өөрчлөлтүүдээс шалтгаалан Монгол Улсын зээлжих зэрэглэл B+ болж сайжирсны зэрэгцээ төгрөгийн ханш сүүлийн нэг жил гаруй хугацаанд тогтвортой байна. Төлбөрийн тэнцлийн цаашдын төлөвт эрдэс бүтээгдэхүүний үнэ, худалдааны түнш орнуудын нөхцөл байдал ирэх оны төсвийн төлөвөөс ихээхэн хамаарахаар байна.

Экспорт сайн байгаа хэдий ч манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч, үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл

үргэлжлэхээр байна. Энэ нь манай экспортын зарим бүтээгдэхүүний үнэ буурахад нөлөөлөх хандлагатай байна. Эдийн засгийн идэвхжил сайн байх үед төсвийн зардал огцом тэлж, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт эхлэхээр байгаа нь импорт валютын төлбөртэй үйлчилгээний зардлыг тэлж, валютын нэмэлт гарах урсгалыг бий болгож, төлбөрийн тэнцлийг муудах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй гэж бас Монголбанкны зүгээс харж байгаа. Иймд улсын санхүүгийн нөөц чадавхыг сулруулахгүй байхад онцгойлон анхаарсан макро бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлж, аливаа хөгжлийн төслүүдийг эрэмбэлэн боломжит гадаад эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл нь нам тогтвортой инфляцын орчинд, орчныг бүрдүүлэх, банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлох, тогтвортой санхүүжилтийн дэд бүтцийг бэхжүүлэх, банк, санхүүгийн салбарт ирж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн сангийн эрх зүйн орчныг сайжруулах зэрэгт онцгойлон анхаарч боловсруулагдлаа. Тогтвортой бага инфляц нь иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулж, тогтвортой өсөлтийг хангах суурь болдог. Монголбанк ирэх 2 жил инфляцыг 6+,-нэгжийн, 6 +,-2 нэгж хувийн интервалд тогтворжуулж, дунд хугацаандаа буюу 2027 оноос зорилтыг 5 хувь болгон бууруулах мөнгөний бодлогын үйл ажиллагааг бууруулахад мөнгөний бодлогын үйл ажиллагааг чиглүүлэхээр тусгалаа. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхэд ЗГ-ын дэмжлэг, төсвийн сахилга бат ихээхэн бас чухал үүрэгтэй болно.

Монголбанк сүүлийн 2 жил гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг нээж хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Цаашид банкны салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж хууль, эрх зүйн орчин зохицуулалтыг боловсронгуй болгоход бас анхаарч ажиллана. Уур амьсгалын өөрчлөлт эмзэг, өөрчлөлтөд эмзэг өртөмтгий түүний сөрөг нөлөөг бодитой үүрч буй манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, дасан зохицох чадавхаа нэмэгдүүлэх нь улам бүр чухал болж байна. Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нарийвчилсан тоон мэдээллийг цуглуулах, банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг эрсдэлийн шинжилгээний аргачлалыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн банк санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө, болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Төлбөрийн систем, зээлийн мэдээллийн үйлчилгээг техник, технологийн хурдтай хөгжилтэй нийцүүлэн сайжруулах, мөнгөний захын дэд бүтцийг олон улсын жишгийн дагуу хөгжүүлэх шаардлага бий болж байна. Иймээс ирэх онд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дотоодын мөнгөний захын хөгжлийг дэмжихэд анхаарч ажиллахаар зорьж байна. Цаашид эдийн засагт гарч буй эерэг үр дүнг бэхжүүлэхийн зэрэгцээ үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Монголбанкны бодлого, үйл ажиллагаа

эдийн засагт гарч буй эрэг өөрчлөлтийг бататгах, инфляцыг дунд хугацааны зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бий болгоход чиглэнэ.

Улсын Их Хурлын гишүүд, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд та бүхнээс Төрийн мөнгөний бодлогыг 2025 онд баримтлах үндсэн чиглэлийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: *Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Найдалаа гишүүнээр, орж байгаа юм уу, Мөнхсоёл гишүүнийг нэмье. Ингээд Жамбалын Ганбаатар гишүүний микрофоныг нээе.*

Ж.Ганбаатар: *Баярлалаа. 3 асуулт асуугаадахъя. Энэ валютын албан нөөц МонголБанкны Ерөнхийлөгчөө 2022 оны 8 сард түүхэн доод хэмжээндээ хүрсэн л дээ. Та өөрөө сайн мэдэж байгаа. Ингээд 24 оны 5 сард түүхэн дээд хэмжээндээ хүрсэн 5,2 тэрбум доллар болсон. Одоо ингээд 4,6 болоод бууж байна. Шалтгаан нь юу байна вэ? Ямар шалтгааны улмаас энэ ингээд буугаад байгаа юм бэ? Уг нь бол нэ чинь хаана явж байгаа билээ 10 Тэрбум долларт хүргэнэ гэчихсэн нэг зорилт зорилго байгаа даа. Тэгээд байнга л өсөх ёстой л гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгээд энэ тэгээд хагас жилээс хойш яагаад буугаад байна вэ? Ямар шалтгааны улмаас бууж байна вэ? Энэ тэгээд манай бас дэг их сонин л доо. Би асуултдаа өөрөө хариулахгүй бол нэг минутад нөгөөдхийг нь тодруулах их сонин.*

Үнэт цаасны үлдэгдэл 9 их наяд төгрөг байна Төв банкны. Энэ ингээд бараг түүхэн дээд хэмжээ байх. Ковидын үеэр овоо буусан, одоо ингээд 9 их наяд төгрөг. Уг нь энэ чинь зах зээлд эргэж байх ёстой мөнгө л дөө. Тэгээд Төв банкин дээр байгаад байдаг. Тэгээд бизнес эрхэлж байгаа хүмүүс зээл авъя гэхээр 22 хувьтай. Бизнесийн зээл яг 22 хувьтай байна лээ. Тэгээд энийг даваад бизнес хийнэ гэдэг зүйл их л хол л доо. Нэлээн хол, нэлээн хол ч юу юм, ер нь бол хэцүү. Тэгээд энэ мөнгөний бодлого уг нь бол энэ бизнес эрхэлж байгаа энэ хүмүүсээ дэмжих хэрэгтэй юм л даа. Улс орны хөгжлийн тулах цэг шүү дээ ер нь бол гол гаргалгаа нь л даа. Тэгээд ярьж байгаа хүмүүс биш л дээ, хийж байгаа хүмүүс л улсыг хөгжүүлнэ. Тэгээд ухаантай, ухаантай юм ярьж байгаа хүмүүс уучлаарай тэгээд хүч нөлөөлөл үзүүлэх байх. Тэгэхээр энийг яаж бууруулах вэ? Тэгээд их наяд, 9 их наяд төгрөг байгаад байдаг. Уг нь энэ чинь жинхэнэ хүмүүсийн гар дээр эргэж байх ёстой л гэж ойлгож байгаа шүү дээ.

Бодлогын хүү 10 хувь болсон байна. Тэгээд яаж бууруулах юм, яаж энэ мөнгийг цааш нь Мөнгөний бодлого энийгээ л гол нь тодруулж хэлмээр байна. Ямар бодлого барих юм бэ?

3 дугаарт тэр Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль ба батлагдсан, 23 оны хэдэн сард билээ батлагдсан. Энэ тэгээд санал ирж байна уу? Ямар нэгэн хүсэл, санал ирж байна уу? Танайх ч зөвшөөрлийг нь өгөх байх, үгүй билүү? Өгч л таараа шүү дээ. Тэгэхээр танай дээр ямар нэгэн санал хүсэлт байна уу? Та нар ажиллаж байна уу? Энэ чинь 2 дахь асуудалтайгаа уялдаатай шүү дээ. Гаднын хөрөнгө оруулалттай банк орж ирж байж л хүү бууна л гэж бүгдээрээ ярьсан. Тэгээд ярьсан цагаас чинь хойш хүү чинь улам өсөөд байх юм. Лхагвасүрэн бол бас ч тийм ч муу ч ажилладаггүй юм л даа. Тэгэхдээ энэ яг тоо баримт чинь бас л нэг тийм гоё үр дүн харагдахгүй л байх юм. Тэгээд энэ их олон хэмжээний мөнгө, хөрөнгө оруулалт хэлбэрээр орох нь байна. Тэгээд хүн болгон асуугаад байсан л даа. Тэгээд инфляц ийм бага байж болох юм уу, чадах юм уу гээд. Тэр бас л асууж байгаа хэлбэр бол зөв л дөө.

Тэр нөгөө Банкны тухай хуулийг баахан хэрүүл болж 26 он болгосон. Тэрийг ахиж сунгана гэсэн ойлголт байхгүй шүү. Лхагвасүрэн Ерөнхийлөгчөө тэрийгээ анхаараарай, хариулаарай бас. Миний минут дууслаа, баярлалаа.

Р.Сэддорж: *5 номерын микрофон Лхагвасүрэн Ерөнхийлөгч.*

Б.Лхагвасүрэн: *Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тийм. Монгол Улсын валютын нөөц түүхэн дээд хэмжээндээ энэ онд хүрсэн 5,2 тэрбум. Тэрнээс хойш бол ерөнхийдөө Монголбанкны Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийн өрийн 50 хувийг төлж барагдуулсан байгаа. Оны эхнээс ингээд 3 удаа ээлж дараатай төлсөн. Тэгээд 12 тэрбум юань өр байсан оны эхэнд. Ингээд 6 тэрбум юанийн өр болж үлдсэн байгаа. Тухайн үеийн ханшаараа бол бараг 2 тэрбум гаруй долларын өр ингэж бичигдээд явж байсан бол, одоо бол яг өнөөдрийн 6 тэрбум юанийг өнөөдрийн ханшинд шилжүүлэх юм бол бараг 800-гаад сая доллар гаруйтай бараг тэрбум хүрэхгүй ийм хэмжээний өр болж буурсан байгаа. Энэ бол тодорхой хэмжээнд бол нөөц бол цаашаа өсөхгүй өсөөгүйд бол бас нөлөөлж, нөлөөлөх нэг шалтгаан болох байх.*

Нэлээн том шалтгаан бол импорт өнгөрсөн онтой харьцуулах юм бол импорт бол 26 хувиар өсөөд явж байгаа. Экспорт 8 хувиар 6 хувиар өссөн, импорт 20 хувиар өссөн. Энэ утгаараа бол импорт дээр ирж байгаа дарамт нь өөрөө нөөцийг өсгөхгүй байхаар бас нэг ийм дарамт болж байгаа. Төлбөрийн тэнцэл дээр байгаа нарийн тоон мэдээллүүдийг бол бид нар бас олон нийтэд хүргээд явж байгаа. Ялангуяа тэр хөрөнгө оруулалтын хэсэг дээр бол нэлээн том өсөлт явж байгаа. Мөн хэрэглээ дээр бас өсөлт явж байгаа. Тухайлан нэг бүтээгдэхүүний хэрэглээг ярих юм бол автомашин бол 8 сарын байдлаар 85 мянган автомашин импортлогдож орж ирсэн байна. Ерөнхийдөө өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол жилдээ 50-аас 60 мянган машин жилдээ орж ирдэг байсан бол эхний 8 сард ингээд 85, энэ оны эцэс хүртэл бол бараг 100 мянга давах болов уу гэсэн ийм төсөөлөлтэй ингээд байж байгаа. Тэгэхээр импортын нэмэгдэж байгаа энэ нэмэгдэл нь бол өөрөө бас нөөцийг тодорхой хэмжээнд өсгөхгүй өсгөхөд бас сөрөг нөлөө үзүүлж байгаа гэж харж байгаа.

Оны төгсгөлд бол Монголбанк бол энэ валютын нөөцийг бол найм аравны, 4,8, 4,8-аас 9-ийн хооронд байх болов уу гэж төсөөлж байгаа. Тийм. Тэгэхээр бол ерөнхийдөө валютын нөөц бол тогтвортой өндөр хэмжээнд бол байж хадгалагдаж чадна гэж харж байгаа.

2 дахь асуудлын хувьд бол үнэт цаасны үлдэгдэл өнөөдөр 8,7 их наяд төгрөг байна. Ерөнхийдөө энэ бол банкнуудын илүүдэл нөөц байгаа банкны. Тэгэхдээ бол энэ нөөцийг илүү зээл гаргана гэх юм бол бас тодорхой тийм эрсдэлийн зүйлүүд бас байгаа. Тухайлбал өнгөрсөн онтой харьцуулах юм бол банкны санхүүгийн нийт зах зээлд гаргасан зээлийн хэмжээ 30 хувиар өсчихсөн явж байгаа. Өнөөдөр нийт зээлийн үлдэгдэл 34 их наядад хүрсэн. Тэгэхээр бол зээл бол өнөөдөр бол хангалттай хэмжээнд өндөр гарч байгаа, 30-аас илүү хувийн өсөлт хэрвээ гарах юм бол энэ өөрөө эдийн засгийг илүү халаах, цаашдаа бүр илүү их хуримтлагдаж эрсдэл бий болгох бас ийм үр дагавар байгаа болов уу л гэж харж байгаа. Тэгэхдээ тэр утгаараа бол өнөөдөр бол зээл дээр бол Монголбанкнаас бол яг зээлийг зогсоож хаасан зүйл байхгүй хэдий ч гэсэн зээл бол өөрөө хангалттай өндөр хэмжээнд өсөөд явж байгаа л гэж харж байгаа. Гарч байгаа зээлийг бол дотор нь хэрэглээний зээл болон бизнесийн зээл гэж ялгаж байгаа. Урьд нь бол…/минут дуусав/

Р.Сэддорж: *Ганбаатар гишүүн тодруулга.*

Ж.Ганбаатар: *Минутдаа багтаад хариулж сур л даа. Ер нь бол валютын нөөц буусан гол шалтгаан биржээр нүүрсээ зарахгүй байгаагаас болж байгаа шүү дээ. Зарахгүй биш л дээ бага зарж байгаагаас. Наадуул чинь бүр даварч байгаа шүү. Намайг Байнгын хороон дээр үг хэлсний төлөө баахан над руу гүтгэсэн шүү наад хүмүүс чинь. Наад нүүрснийхэн чинь том бүр их том болох нь л дээ. Наад нүүрсээ биржээр заруул л даа. Тэгж байж наад валютын чинь нөөц чинь тогтвортой өсөх ёстой шүү дээ. Өмнөх 4 жилд баахан өр төлсөн шүү дээ, энэ жил төлөөгүй шүү дээ Лхагвасүрэн. Бид нар чинь баахан өр төлөөд баахан зарласан шүү дээ. Тэгээд ганцхан энэ удаа тэр юанийн зээл төлчихсөн юм биш шүү дээ. Өмнөх жилүүдэд төлөөд, өсөөд болоод байсан юм. Төлөөд өсөөд. Тэр 3 дугаар асуултдаа хариулт аваадахъя.*

Р.Сэддорж: *5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Ганбаатар гишүүний асуултад тодруулаад хариулъя. Тэгээд Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль төрөлжсөн банкны тухай хууль батлагдсан. Тэгээд өнөөдөр бол яг Монголбанкин дээр Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хуулийн дагуу ч тэр, Арилжааны банкны хуулийн дагуу ч тэр ямар нэг хүсэлт банк байгуулъя, банкны салбар нээе гэж хүсэлт ирээгүй байгаа. Тэгээд нэг тийм байгаа юм.*

2 дахь Банкны тухай хуультай холбоотой асуудал нь бол өнгөрсөн онд бол арилжааны 5 банк Хөрөнгийн биржээр IPO хийж 500 тэрбум төгрөг босгосон. Нөгөө хуулийн дээд хязгаар буюу 20 хувийн заалтыг хангаж ажиллуулахын тулд дахиад хувьцааны төвлөрөл нь 60, 70 хувьтай хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг доошоо буулгахад 10 хувиа ингээд Хөрөнгийн биржээр зарахад 500 тэрбум болж байгаа юм бол дахиад 50 хувийг буулгахад 2,5 их наядын ийм хөрөнгийн шаардлага гарчихна. Тэгэхээр МХБ банкны IPO хийсний дараа өөрөө арилжаа нь 2 дахин нэмэгдсэн. Хөрөнгө, хөрөнгийнх нь хэмжээ нь 3 дахин өсөөд ер нь бол бараг тулчихсан гэж ойлгож болох учраас…/минут дуусав/

Р.Сэддорж: *Баярлалаа. Хассуурийн Ганхуяг гишүүн.*

Х.Ганхуяг: *Банкны хууль болон Төв банкны бид нар хараат бус байдлыг бий болгох, тэрийг хадгалахын зорилгоор бол үндсэндээ 7, 8 хуулиар ингээд баталгаажуулж хамгаалж явдаг. Тэгээд энэ 2 асуудал байгаад байна л даа. Энэ бодлогын хүүгээ хэн нэгний хэлснээр бууруулдаг, хөдөлгөдөг асуудлаа болимоор байна. Төсөв тэлсэн энэ зах зээлээ, эдийн засгаа, төсөв мөнгөө харж байгаад бодлогынхоо хүүг оролддог байхгүй бол төсөвт тэлээд л баталсан, бодлогын хүү өөрчлөөд л одоо ингээд л ханш чинь 70-аас 80 төгрөгөөр суларчихсан байж байгаа байхгүй юу. Энийг нэг цаашдаа анхаарч явмаар байна.*

2 дугаар асуудал энэ хөнгөлөлттэй янз янзын зээл хөтөлбөр гээд энэ жил чинь бараг 4,5 их наяд төгрөг энэ янз янзын төсөл, хөтөлбөрт зориулж хөнгөлөлттэй зээлүүд олгосон байдаг. Нөгөө хүүгийн хөнгөлөлт ч байдаг юм уу. ЗГ-аас юу ч гарч болно. Гэхдээ Төв банк бол хараат бус байх ёстой. Тийм зээл гараад эхлэхээр л энэ эдийн засагт чинь, энэ зах зээл дээр чинь зээлийн хүртээмж нь байхгүй болчхоод байгаа байхгүй юу. Тийм зээлийг та бүхэн дэмжээд эхлэхээр энэ зээлийн хүү чинь буурахгүй байгаад байгаа юм. Тэгээд яг энэ асуудал дээр маш анхааралтай ханддаг баймаар байна. Шаардлагатай бол та бүхэн чуулганд ирээд ирж ярьж болно шүү дээ. Эсвэл Байнгын хороон дээр ирж. Үнэхээрийн боломжгүй асуудлыг, та түр байж байх уу? Асуудал байвал Байнгын хороон дээр

асуудлуудаа танилцуулаад шийдүүлдэг баймаар байна.

3 дугаарт энэ ипотекийн зээл дээр бол 2 төрөл дээр нэг жоохон илүүтэй анхаарчихмаар байгаа юм. Тэгээд энэ дээр бас боломж нь байдаг юм уу, үгүй юм уу? Ерөөсөө анх удаагаа байр авч байгаа иргэн мөн гэр хорооло эрчим хүчний хэмнэлттэй амины сууцад илүүтэй анхаардаг болчихвол бид нар тэр зээлээр чинь олон асуудлыг шийдэх боломжтой болно шүү дээ. Нөгөө утаа, нөгөө хөрсний бохирдол, түгжрэл гээд энэ олон асуудлын зангилаа нь өөрөө энэ хоёрын энэ 2 төрлөөр зээлийн олголтыг нэмэгдүүлчихвэл Улаанбаатарчуудын хувьд бол бас нэлээн том асуудал шийдэх боломжтой байгаа байхгүй юу. Энэ дээр нэг анхаарчихмаар байна.

Мөн дараа жилийн энэ алтаа уг нь болж өгвөл биет байдлаар нь экспортлохоо болиод нөгөө валютын нөөцөө биет, алтаа биет байдлаар нь хадгалаад л явсан бол зөвхөн энэ жил гэхэд та бүхэн 500-гаад сая доллар илүү орлого олох боломжтой харагдаж байгаа байхгүй юу, 500-гаад сая доллар зүгээр алтны үнэлгээ дээрээс. Тэгээд та бүхэн маань Ирээдүйн өв сангийн мөнгийг хадгалж байгаа. Сангийн яамтайгаа ярьж байгаад Ирээдүйн өв сангийн хуримтлалаа алтаар бий болгоод явах тодорхой хэмжээг нь энэ зохицуулалтыг хийгээч. Ирэх жил бол алтны үнэ урьдчилсан прогнозоор 3 мянган доллар хүрэх прогнозтой л байна шүү дээ ханш нь. Тэгээд энэ асуудлууд дээр 2-т хариу авчихмаар байна.

Мөн 2022 онд бас нэлээн асуудал ярьж байж батлуулсан миний эх барьсан хууль байгаа Банкны хууль гээд. Тэгээд хэрэгжилт бол жоохон хангалтгүй байгаа. Лхагвасүрэн Ерөнхийлөгч маань энэ дээр бас нэг жоохон анхаарал хандуулж явмаар байна. Хувьцааны задралт хангалтгүй байна. Мөн банкнууд зөвхөн банкны бизнес хийнэ гээд хууль батлагдчихаад байхад тэнд чинь барилга барьдаг ч банк байна, ингээд тэр брокерын компанийн үйл ажиллагаа явуулдаг ч банк байна, даатгалын үйл ажиллагаа явуулдаг ч банк байна энэ асуудлаа нэг тийш нь цэгцэлмээр байна. Та нар зөвхөн 20 хувиа л яриад яваад байна л даа. Тэгэхдээ тэр Банкны хуулиар чинь бид нар банкийг зөвхөн банкны бизнес хийнэ шүү гээд хатуу оруулсан шүү дээ. Тэр асуудлаа ядаж ирэх жилдээ багтаагаад бүгдийг нь цэгцэлчихсэн баймаар байна. Тэр банкнууд чинь өөр төрлийн бизнестэй нэг бол зардаг, зарчихсан байх хэрэгтэй. Мөн тэр 20 хувьтай холбоотой хувьцааны задралын асуудлаа ер нь нэг болж өгвөл Байнгын хороон дээр ч байдаг юм уу нэг танилцуулгаа, төлөвлөгөөгөө нэг танилцуулчихмаар байна. Тэгэхгүй бол энэ чинь ганц хүн орилоод л…/минут дуусав/

Р.Сэддорж: *Хариулт 5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Тийм би Ганхуяг гишүүнтэй бол бүрэн санал нийлж байна. Ялангуяа бодлогын хүү, хөнгөлөлттэй зээл гарч байгаа энэ процесс дээр бол Төв банкны бие даасан, хараат бус байдал бол зайлшгүй байх шаардлагатай. Тэр утгаараа ч гэсэн ингээд манай Мөнгөний бодлогын хороог бол Улсын Их Хурлаас томилдог. Тэгэхээр Мөнгөний бодлогын хороо бол одоо 6 гишүүнтэй. Тэгээд бодлогынхоо шийдвэрийг дандаа энэ Мөнгөний бодлогын хороон дээр гаргаж явдаг учраас ерөнхийдөө бол энийгээ хадгалах чиглэл рүүгээ бид хэд бас анхаарч ажиллая.*

Тодорхой хариултууд авсан асуулт дээр нь ипотекийн зээл дээр бол энэ оноос эхлээд Хуримтлалын сангийн эх үүсвэр орж ирж байгаа учраас бол нэлээн нэмэгдэж байгаа. Тэгээд Ганхуяг гишүүний хөндөж байгаа яг анх ипотекийн зээлд хамрагдаж байгаа хүмүүсийг илүү их анхаарч үзэх, ялангуяа тэр зөвхөн ийм нийтээрээ бөөн олноороо амьдардаг олон давхар байшин гэхээсээ

илүү бас хашаа хороонд, хашаандаа, өөрийн эзэмшил хашаандаа эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц бариад тэрэнд нь ипотекийн зээл гардаг энэ эрх зүйн зохицуулалтыг оруулж өгч байгаа, Барилга, хот байгуулалтын яамтай яриад яг тэр стандартыг нь гаргаж байгаа.

Өмнө нь бол яагаад олгож байгаагүй вэ гэхээр өмнө нь бол энэ олон давхар байшингуудыг бол улсын комисс аваад, улсын комиссын гаргасан тэр мэргэжлийн баталгаа дээр нь банк зээлээ олгодог бол, хашаанд барьж байгаа орон сууцын байшинд нь хэн нэгэн хүлээж авч, хэн нэгэн мэргэжлийн хөндлөнгийн байгууллага баталгаа нөгөө сертификат өгдөггүй болохоор банк бол барьцаа авч чаддаггүй байсан. Одоо энийг бол өгдөг болгохоор эрх зүйн зохицуулалт Барилгын тухай хууль дээр оруулъя гэж БХБЯ ярьж байгаа юм. Тэгэхээр тэрүүгээрээ энэ өөрөө ингээд ороод ирж байгаа. Тэр утгаараа бол хашаандаа барьж байгаа амины орон сууц, тэр нь өөрөө мэргэжлийн байгууллагаар хянагдаж баталгаажих юм бол шууд ипотекийн зээлийн барьцаа болох боломжтой болох юм. Тэгэхээр энэ ажил бол 25 онд бол бараг эхлээд хийгдээд явна гэж харж байгаа.

Алтны хувьд бол Монголбанк өөрийн худалдаж авсан алтаа Европт цэвэршүүлдэг. Тэгэхдээ сүүлийн үед бол цэвэршүүлсэн алтаа буцааж авчирч байгаа, тодорхой хэмжээний алтыг бол өөр дээрээ хадгалж байгаа. Тийм. Тэгээд энэ нөгөө валютын нөөц нөгөө төрийн нууцтай холбоотой мэдээлэл учраас би танд нарийн тоо хэлж чадахгүй байна. Тэгэхдээ таныг яавал би бүүр нарийн тоонуудаа хэчнээн хэмжээний гэдгээрээ ингээд хэлээд болно.

Банкны тухай хуулийн хэрэгжилтийг бол ерөнхийдөө түрүүн би бас Ганбаатар гишүүний асуултад хариулахад яасан. 26 оны эцэс хүртэл бол Монголбанк хяналтаа тавиад явна. Тэгээд хувьцааны төвлөрлийг бууруулаад явах тал руу яаж байгаа. Энэтэй холбогдуулаад яах вэ гаднын хөрөнгө оруулагчид тавьж байгаа санал байгаа. Банкны тухай хууль дээр нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч хяналтын багцыг авч байгаа хувьцаа эзэмшигч нөгөө банкны бас тийм нөлөө бүхий байж болохгүй гэдгийг хориглосон заалт байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө ялангуяа тэр Европын сэргээн босголт, Олон улсын санхүүгийн корпорац гэдэг байгууллагууд нэг биш нэлээн хэдэн банкин дээр хувьцаа авахыг нь бол энэ хуулийн хязгаарлалт хаагдаад байгаа учраас энийг нээж өгөх талаар бол асуудал тавьсан. Тэгээд Банкны тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирье гэдгээрээ төслөө бичээд явж байгаа. Тэр банкны, банк өөр бизнес эрхэлж байна гэдэг дээр нь жоохон маргаантай…/минут дуусав/

Р.Сэддорж: *Ганхуяг гишүүн тодруулга.*

Х.Ганхуяг: *Нөгөө эцсийн өмчлөгчөөр нь та бүхэн маань өөрөө хамаарал бүхий этгээд байна уу, үгүй юу гэдгийг бол угаасаа тогтоочих боломжтой байх. Тийм болохоор банк банкнаас өөр төрлийн бизнес эрхлэхгүй гэдгийг бол Төв банк бол тэрийг бол амархан шийдчих байх. Тэгэхээр энийгээ наад асуудлаа шийдчихмээр байн.*

2 дугаарт саяын тэр нөгөө нэг хувьцаа эзэмшигч бусад банканд хувь эзэмшиж болох уу гэдэг асуудлыг бол нэлээн сайн бодож байгаад оруулж ирнэ шүү. Тэр Европын сэргээн босголт банкийг бол окэй, тэр бол зөвшөөрч болж байна. Гэхдээ нөгөө гадаадын оффшор банкнуудаар, оффшор нэрээр нэг хүн олон банканд эзэмших асуудлыг бол байж болохгүй асуудал. Энэ чинь бол манайхан бол гадаадад нэг компани бүрдүүлээд л тэгээд гаднын нэртэй банк болоод л ингээд л явчихдаг юу бол асуудал байдаг шүү дээ, энийг бол мэдэхгүй бол бараг хүн байхгүй л байх. Тэгэхээр

тэрийгээ оруулж ирэхдээ харин тэгж томьёолж оруулж ирмээр байна. Тэгээд өөр хуультай холбоотой саад бэрхшээл байвал наана нь сайн мэдэгдэж баймаар байна. Мөн саяын ярьсан ипотекийн эх…/минут дуусав/

Р.Сэддорж: *Үг хэлж, асуулт асуух гишүүн дээр Алтаншагай гишүүнийг нэмье. Хариулт 5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Ганхуяг гишүүний асуултад тодруулаад хариулчихъя. Тийм. Энэ нөгөө эцсийн өмчлөгч гэдгээрээ эцсийн өмчлөгч бол шууд л хувь хүн, хуулийн, хувь хүн байх юм. Тэгэхээр хувь хүн нь өөрөө Монгол хүн байна уу, гадаад хүн байна уу гэдгээрээ эцсийн өмчлөгчийг тодорхойлох учраас ямар нэг оффшороор дамжих ч юм уу, гаднаар орж ирэхэд бол Монголбанк бол тэрэнд зөвшөөрлийг нь өгөхгүй байх бүрэн боломжтой гэж харж байгаа юм.*

Ипотекийн эх үүсвэрийн хувьд бол энэ жил бол Хуримтлалын сангаас 500 тэрбум төгрөг орж ирсэн. Ер нь бол Улсын Их Хурлаас гаргасан тогтоолын дагуу бол Монголбанк эргэн төлөлтөөрөө санхүүжүүлж байгаа. Тэр нь 500, банкны оролцоо нь 200 тэрбум, тэгээд Хуримтлалын сангийн гээд 1,2 их наядын санхүүжилт энэ онд олгогдоно. Ирэх онд бол яг энэ хэмжээнээсээ буурахгүй байх гэж харж байгаа. Гэхдээ ерөнхийдөө энэ 6 хувийн хөнгөлөлттэй зээлийг бас энэ хотын төв хэсэг дээрээ бол арай өөр хүүтэй байхаар бас саналууд явж байгаа учраас хэрвээ хүүгийн ийм ялгавартай тогтоосон зүйл орж ирэх юм бол банкны оролцоо нэмэгдэх юм. Өнөөдөр бол банк бол өөрийнхөө нөхцөлөөр 12-оос 14 хувийн хүүтэй ипотекийн зээл олгоод явж байгаа юм. Энэ нь бол ямар нэг очер дараалал юм уу, асуудалгүй байгаа учраас…/минут дуусав/

Р.Сэддорж: *Баярлалаа. Отгоншарын Батнайрамдал гишүүн.*

О.Батнайрамдал: *Баярлалаа, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл. Энэ үед бол макро эдийн засгийн эрсдэл талаасаа зайлшгүй ярих ёстой. Тэр нь өнөөдрийн бидний яг макро эдийн засгийн түвшнийг аваад үзэх юм бол төсвийн зарлага түүхэн хэмжээндээ хүрчихсэн, 25 оны төсөв бол бүр илүү давж орж ирэхээр харагдаж байгаа. Мөнгөний нийлүүлэлт, зээл олголт талаасаа харахаар энэ чинь 31,5 энэ аягүй өндөр өсөлт л дөө. Тэр дундаа та яг хэллээ иргэдийн зээлийн өсөлт тэр дундаа 22,3 хувиар өсчихсөн, нэлээн тэлчихсэн. Бас импортоо аваад үзэх юм бол импортын өөрчлөлт 1,1 тэрбум буюу сүүлийн 5 жилд бас хамгийн өндөр хэмжээндээ хүрчихсэн, энэ цаашаа ч тэлэхээр харагдаад байна л даа.*

Тэгэхээр яг энэ үед бол 2024 оны 9 сард хүү 1 хувиар буурсан тийм ээ? Тэгээд дөнгөж уржигдархан бас ОУВС Монголд ирсэн, өөрсдийнхөө яг Монголд айлчилсан тэр талаараа тайлангаа гаргасан байна л даа. Тэгээд яг тайлан дээр нь бол яг энэ талаар бас нэлээн эрсдэл талаасаа дурдсан байна л даа. Нэг ёсондоо ийм халалтын, эдийн засгийг халах талаас нь харах юм бол нэлээн олон индикатор эдийн засаг ер нь халж байна гэдэг индикатор энэ байгаа үед мөнгөний бодлого талаасаа хүүгээ бууруулаад, илүү тэлэлтийн бодлого явахаар бид нар илүү улам л халаана л гэж мессеж явуулаад байна л даа. Зээлээ харахаар энэ чинь 31,5 хувиар өсчихсөн. Тэгэхээр энийг та бас юу гэж бодож байгаа юм бол? Энэ ОУВС-ийн энэ дүгнэлтийг.

Тэгээд дээрээс нь мэдээж 25 онд хамгийн том эрсдэл бол эрсдэлийн нэг энэ төлбөрийн тэнцэл дээр маш том дарамт болж орж ирэх нь ойлгомжтой л болж байна л даа. Сая Ганбаатар гишүүн ч хэлчихлээ. Ер нь гадаад валютын албан ёсны нөөцөө аваад үзэхээр 6 улирал тэлж явж байснаа буураад эхэлчихлээ л дээ. Тэгэхээр энэ ер нь цаашдаа буурах хандлага руу нэг ёсондоо орж байгаа үр

дүн харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг яах вэ?

25 онд дээрээс нь бас бидний нэг тооцох ёстой юм Оюу толгойн бүтцийн шилжилт шүү. Оюу толгой яах вэ урсгал зардлын хүрээнд нэг ойролцоогоор 800 сая тэрбум доллар орж ирдэг. Энэ бол угаасаа сүүлийн 5, 6 жил орж ирдэг л урсгал байхгүй юу. Энэ өөрчлөгдөхгүй энэ чинь үндсэн 5 мянган ажилчныхаа цалинг төлнө шүү дээ. Гэхдээ бүтээн байгуулалтын хэмжээнд орж ирдэг тэр 2024 онд гэхэд 2 тэрбум доллар орж ирэхээр төсөөлөлтэй юм. Энэ байхгүй болчихно шүү дээ. Энэ байхгүй болчих байхгүй юу. Тэгэхээр энэ бол өөрөө тэгшитгэл дээр маш том өөрчлөлтийг авчирна шүү. Энийг ерөөсөө багаар харж болохгүй юм.

Дээрээс нь яг энэ иргэдийн зээлтэй холбоотой. Иргэдийн зээл бол өндөр тэлэлтийг гаргасан. Сүүлийн жилд бол тэр дундаа хамгийн эрсдэл дагуулсан 25 онд яалт ч үгүй хамгийн том эрсдэлийн нэг бол энэ давхар зээлийн асуудал. Яг финтек зээл 350 мянган иргэн финтек зээл авсан давхар зээл. Энэ давхар зээлийг аваад үзэхээр энэ чинь ББСБ-ын нийт зээлийн багцын 62 хувийг эзэлж байгаа шүү дээ. 62 хувь давхар зээл. Өр, орлогын харьцаагаа харах юм бол энэ дээр бодлогын аягүй уялдаагүй зүйл ажиглагдаж байна. Энэ явж, явж хамгийн том эрсдэл шүү. Банкны өр, орлогын харьцаа авах юм бол 50 орчим хувьтай тийм ээ дажгүй болж байгаа юм банк талаасаа. Гэхдээ ББСБ дээр байгаа өр, орлогын харьцааг аваад үзэх юм бол энэ чинь 80 гарчихсан явж байгаа байхгүй юу 80 хувь болчихсон. Нэг ёсондоо иргэн татварын дараах 20-хон хувийнхаа орлогоороо амьдарч байна гэж энэ чинь утгагүй зүйл болно л доо.

Тэр дундаа финтек дээр Санхүүгийн зохицуулах хороо хязгаарлалт тавьсан боловч уламжлалт зээл дээр ерөөсөө ямар ч хязгаарлалт байхгүй байгаа юм. Уламжлалт зээл, банк бус санхүүгээр гарч байгаа уламжлалт зээл чинь нийт багцынхаа 62,5 хувь байхгүй юу. Тэгэхээр тэр 62,5 дээр ямар нэгэн хязгаар байхгүй гэдэг чинь хэрэглэгч талаасаа харах юм бол тэр банкнаас зээл авсан байна уу, банк…/минут дуусав/

Р.Сэддорж: *Хэн хариулах вэ? 5 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.*

Б.Лхагвасүрэн: *Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тийм ерөнхийдөө энэ жил ингээд 24 онд төсвийн тодотгол хийсэн. Төсвийн тодотголоор төсөв өөрөө 3 их наядаар тэлсэн байгаа. Ирэх оны төсөв бол өөрөө зардал нь 35,8, орлого нь 33,9 гээд 1,8 их наядын алдагдалтай ийм төсөв орж ирж байгаа. Тэгээд энэ нь өөрөө бас яг ДНБ-ий 37 хувь гээд ковидын өмнөх 27-гоосоо бол бүүр ингээд 10 нэгж хувиар ингээд өндөр ийм л том төсөв л яваад байгаа л даа. Тэр утгаараа мэдээж макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тал руу нь мөнгөний бодлого дээр бол яалт ч байхгүй хатуу л байхаас, хатуу төлөвөө хадгалахаас өөр замгүй байгаа юм. Тэр утгаараа яах вэ сая 9 сард манай бодлогын хүү 1 нэгж хувиар буураад 10 болсон ч гэсэн 10 гэдэг тоо бол өөрөө манай өнөөдрийн энэ 6,7 хувийн инфляцаас өөрөө даруй 3,3 нэгж хувиар өндөр эерэг байна гэдэг маань өөрөө хатуу бас төлөвөө хэвээрээ байгаа л гэж харж байгаа юм. Тэр утгаараа би зүгээр энэ оныг дуустал ч гэдэг юм уу, дараа оны эхэн хүртэл бол мөнгөний бодлого дээр бол ямар нэг бодлогын хүү талаасаа бол өөрчлөлт ер нь гарахгүй болов уу гэж бидний Төв банкны зүгээс яг бол харж байна. Тэр утгаараа бол мэдээж мөнгөний хатуу бодлого бол үргэлжилсэн хэвээрээ явна.*

Сая ОУВС-ийн баг ирсэн s… visit гээд. Ерөнхийдөө тэр дүрмийн 4 дүгээр заалтын үнэлгээний баг биш, зүгээр Монголыг хариуцдаг баг ирээд ажиллаад явсан. Ер нь бол Монголбанкин дээр бол бас л яг л мөнгөний хатуу бодлогоо нэг

хэсэгтээ тодорхой болтлоо л харах ёстой л гэдэг л талаар бид хэд ярилцсан байгаа. Тэгэхээр ер нь бол мөнгөний бодлогын төлөв хатуу хэвээрээ байна гэж ойлгож болно.

Экспорт, импортын талдаа бол жоохон төвөгтэй үйлдэл үүсэж байгаа нь бол тэр таны саяын хэлж байгаа зүйлүүд байгаа юм. Тийм. Тэгэхээр импорт нь өөрөө 26 хувь, экспорт нь өөрөө дөнгөж 6 хувийн өсөлттэй байгаа нь бол дарамт бол төлбөрийн тэнцлээ ч алдагдуулах тал руугаа дарамт, дээр нь ханш, нөөц дээрээ ч дарамт болж ирж байгаа юм. Монголбанкны зүгээс бол яах вэ зүгээр онолын хувьд бол энийг бол гол нь чөлөөтэй ханшны тогтолцоогоороо бол ханш өөрөө ингээд хэрвээ сулраад явах юм бол импортоо хязгаарлах, экспортоо дэмжих тал руу нь явах л бодлого болно л доо. Гэхдээ Монгол Улсын онцлог бол өөрөө манай хэрэглээний сагсны 420 бүтээгдэхүүний бараг 50-аас илүү хувь нь өөрөө импортын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ байгаад байгаа л даа. Тэгэхээр хэрвээ инфляц ханш дээрээ ингээд жоохон сулруулах маягаар өөрөөр нь тогтворжуулах зүйлийг хийх юм бол эргээд инфляц дээрээ дарамт гарч ирэхээр байгаа. Яагаад гэвэл нөгөө хэрэглээний сагсны чинь 50-аас илүү хувь нь импортын бараа бүтээгдэхүүн байгаа учраас. Тэгээд ханш бол тогтвортой нэгэнт ингээд байгаа энэ үед нь бол тэр тал руу нь явах нь бол бас илүү их сөрөг үр дагавар гарч магадгүй л гэж Монголбанк харж байгаа. Тэр утгаараа яах вэ импортыг аль болохоор…/минут дуусав/

Р.Сэддорж: *Батнайрамдал гишүүн тодруулга.*

О.Батнайрамдал: *Лхагвасүрэн Ерөнхийлөгчөө тэгээд тэр ер нь эрсдэл ББСБ талаасаа ялангуяа тэр хязгаарлалт байхгүй уламжлалт зээл талаасаа л гарч ирэх юм бол тэр банк, банк бус гэж ялгахгүй шүү дээ. Тэгэхээр энэ Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хоёрын яг хамтарсан маш бодлогын уялдаатай яг энэ хязгаарлалтууд өр, орлогын харьцаа дээр ялангуяа энд яалт ч үгүй энэ дээр бодлогын тийм зөрөө ч гэх юм уу, алдаа харагдаад байна л даа. Тэгэхээр энийг анхаарахгүй бол банк нь, банк бус нь манайд хамаагүй, банк нь л манайд хамаатай гэж байгаад яг эндээсээ их гарч байгаа эрсдэл бол бараг банкаа татаж унагаах ч юм уу эсвэл нэг тиймэрхүү эрсдэл харагдаад байна гэж хэлэх гээд байгаа юм 1 дүгээрт.*

2 дугаарт бас энэ Европын банкнуудыг Төв банкнуудыг бас аваад үзэхэд тэд нарын хамгийн том эрсдэл Ernst and young-н 2024 оны судалгаа байгаа юм. Европын бүх банкнуудаас асуухад хамгийн том эрсдэлийг тэд нар cyber security ерөөсөө кибер аюулгүй байдлын…/минут дуусав/

Р.Сэддорж: *Батнайрамдал гишүүн нэмж цаг авах уу? Тийм, асуулт тодруулгаа гүйцээчих.*

О.Батнайрамдал: *Тэгэхээр кибер аюулгүй байдал бол Европын Холбоо, барууны банкнуудын хамгийн өндөр эрсдэлүүдийн 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Тэгэхэд манай мөнгөний бодлого дээр кибер аюулгүй байдлын талаар, эрсдэлийн талаар нэг ч үг дурдаагүй байх юм. Энэ бол миний үндсэн чиглэл дээр бол заавал орох ёстой сэдвийн нэг гэж бодож байна.*

2 дугаарт бас ипотек дээр нэг зүйл хэлэх гэсэн юм. Ипотекийг бид нар 24 оны 8 сараар аваад үзэх юм бол ипотекийн нийт олголтын чинь 30, 40 хувь нь зөвхөн Хан-Уул дээр олгогдсон байна. Хан-Уул дүүрэгт Улаанбаатар хотын. Тэгэхээр энэ нь юу гэсэн үг вэ гэхээр уг нь ипотекийг чинь бид нар анх удаагаа байр авч байгаа, гэр хорооллоос орон сууц руу орж байгаа хүмүүс байх байтал 40 хувь нь Хан-Уул дээр буюу өндөр үнэтэй тэр барилгууд руу ороод

байхаар Ипотекийн бодлого чинь өөрөө буруу яваад байна. Энэ дээр та бүхэн бас ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа гэсэн ийм асуултууд байна. Хариулт авъя.

Р.Сэддорж: *5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Батнайрамдал гишүүний асуултад тодруулж хариулъя. Тийм СЗХ-нд бол ер нь бол анх энэ хэрэглээний зээлээ чангалж явахдаа саналуудаа тавьж байсан. Бүр ер нь бол 5, 6 нэлээн олон удаа саналууд тавьсан. Яах вэ сүүлийн үед СЗХ-ноос ирсэн албан тоот дээр бол одоо манайхыг дагая гэдгээрээ тоот ирж байгаа. Тэгэхээр удахгүй СЗХ өөрийн нөгөө хяналт шалгалтад байдаг банк бус санхүүгийн байгууллагуудтай өр, орлогын харьцаа ч гэдэг юм уу, энэ хэрэглээний зээл дээр хязгаар тавьсан арга хэмжээнүүд авна гэж ойлгож байгаа. Тэгэхээр бол авчих байх гэж найдаж байгаа.*

Кибер аюулгүй байдалтай холбоотойгоор Монголбанк бол өөрөө Дэлхийн банктай хамтраад өөрийнхөө кибер аюулгүй байдлын талаар тэгээд Монгол Улс өөрийнхөө хэрэглэж байгаа бүх software аппликэйшн, бүх программ хангамжийнхаа юман дээр бол олон улсын нөгөө ISO27009 гэдэг байхаа тэр юуг нэвтрүүлэхээр ингээд ажиллаж байгаа болохоор, бид угаасаа өөрсдөө хийж байгаа ажлаа бол энэ дээрээ нэг их яагаад яах вэ гэж бодоод оруулаагүй юм. Мэдээж арилжаа…/минут дуусав/

Р.Сэддорж: *Баярлалаа. Энхбаярын Батшугар гишүүн.*

Э.Батшугар: *Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Зээлийн хүүгийн асуудал мэдээж бид нарын Монголчуудад хамгийн тулгамдсан асуудлын нэг. Жигнэсэн дунджаар бол 18 хувьтай байна. Гэхдээ энийг хүүг бууруулах хамгийн амархан болон хурдан хийх арга бол юу л байна л даа. Нөгөө Актив удирдлагын компани байгуулах. Энэ бол яг судалгаагаар 30 хувиар хүүг нь бууруулах бололцоотой гэж харж байгаа юм. Тэгэхээр чинь 18 хувийн жингэнэсэн дундаж хүү шууд 12 луу ирж буурах бололцоотой. Тэгээд манай Монгол Улсад энэ ажил нэг хийгдэх гэж өргөн баригдах гэж байснаа тэгээд больсон. Тэгээд энэ ажил аль түвшиндээ явж байгаа вэ? Яг миний түрүүн хэлснээр судалгааны дагуу энэ 30 хувиар зээлийн хүү буурах бололцоотой юу гэж асууя.*

2 дахь асуудал яах вэ нийт төсвийн орлого М2-той харьцуулах харьцаа дэлхийн дундаж орнууд ялангуяа хөгжиж байгаа улс оронд нэг 20-оос 25 хувьд л байдаг юм байна лээ. Манайх бол бараг 60 хувьтай байгаад байгаа юм. Тэгэхээр үүн дээр Монголбанк энийг яаж харж байна вэ? Хэт төсвийн тэлэлт яваад, үүний ч дагуу зах зээлд байгаа мөнгийг төр нь өөрөө аваад, ААН-үүд хувийн хэвшилдээ юм үлдээхгүй, үүний адил зээл олдохгүй байна гэсэн шүүмжлэл гарч байгаа юу? Энэ нэг юу л байна л даа. Энэ их зөв гэж би харж байгаа юм. Энэ нөгөө нэг ёсны money market operations-нийг нээх гэсэн байгаа юм байна шүү дээ ирэх долоо хоног, ирэх жил. Энэ нь бол нөгөө нэг ЗГ-ын үнэт цаас болон Төв банкны үнэт цаасны хүүгийн зөрөөгөөр энийг бол маш дэмжиж байгаа. Өнөөдрийн үүгээр дамжуулаад түрүүн бас Ганбаатар гишүүн хэлсэн Төв банкны үнэт цаас дээр бол бараг 10 их наяд төгрөг байна. Энийг бол эсрэгээрээ money market operation руугаа оруулаад, тэгээд капитал маркетаа илүү идэвхжүүлэх бололцоо нээгдэж байна л даа. Тэгэхээр энийг аль болохоор хурдан хийгээрэй гэж хэлье.

Төлбөрийн тэнцэл энэ ондоо ч сөрөг гарна, ирэх ондоо ч сөрөг гарах тийм төсөөлөл байна л даа. Үүгээрээ дамжуулаад энэ төлбөрийн тэнцлийн алдагдал чинь бол шууд л манай Монгол Улсын гадаад валютын нөөц дээр ирдэг. Одоогийн байдлаар -190 орчим сая доллар алдагдалтай байна. Энэ ондоо энэ ч нэмэгдэх тийм төлөв байдал харагдаж

байна л даа. Ирэх жил ч гэсэн бол энэ нэг их тийм эерэг тийм төсөөлөл харагдахгүй байна. Тэгэхээр үүн дээр бас Монголбанкны зүгээс ямархуу арга хэмжээ авах вэ?

Юу байгаа юм энэ нөгөө нэг Central bank digital currency болон CBDC сүүлийн үед бол дижитал төгрөг гэж хэлнэ л дээ Монголоор орчуулбал, их хэрэгжиж эхэлж байна. Одоогийн байдлаар 11 дэлхийн Төв банк ашиглаж байна, 55 дэлхийн Төв банк болоод орны банк энийгээ нэг ёсондоо f... дээр тестинг хийж байна. Мөн 79 улс орны Төв банк бол одоо яг үүнийг хэрэгжүүлэх гээд бэлтгэл ажлаа хангаж байгаа. Тэгэхээр энэ утгаараа Монголбанк үүн дээр бас нэг их анхаарал хандуулаад бас хэрэгжүүлсэн нь зөв юм уу гэж харж байна. Яагаад гэвэл энэ чинь өөрөө мөнгөний бодлогын хэрэгслийг улам эдийн засаг бодит үр дүн авчирна. Дээрээс нь нэмээд хяналт болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх том хэрэгсэл болчхоод байна л даа.

3 дахь нэг сүүлийн нэг зүйл байна л даа. Энэ гадаадын хөрөнгө оруулагч /ГХО/ Монголд авчрахдаа төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээч. Монголбанкны үндсэн чиглэл дээр ч гэсэн дэлгэрэнгүй биччихсэн байна. Тэгэхээр нөгөө нэг санхүүгийн үүсмэл хэрэгслийг яаж хөгжүүлэх вэ Монгол Улсын банкны салбарт? 90-ээд оноос хойш ерөөсөө үүсмэл хэрэгсэл бараг л ажиллаж өгөхгүй, хэрэгсэлгүй, хэрэгжихгүй байна. Ялангуяа нөгөө нэг currency a... бол энэ бол ямар байдлаар бид нар дэмжиж, ГХО-дыг Монгол Улсад авчраад, мөн ГХО-дын хамгийн том анхааараад байгаа зүйл нь currency risk явдаг шүү дээ. Энийг нь ямар байдлаар цөмөөрөө h... хийж өгөх вэ? Ийм асуулт байна, асуултууд байна. Баярлалаа.

Р.Сэддорж: *5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Батшугар гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт Активын удирдлагын компани. Энэ активын удирдлагын компанийг байгуулахаар Активын удирдлагын компанийн тухай хуулийг 2017 онд байх, 19 онд төслийг нь яагаад тухайн үед бол Улсын Их Хурлын гишүүнээр дамжуулан өргөн барьж байсан. Тухайн үедээ бол Азийн хөгжлийн банк бол энэ бол яг болж байна гэдгээрээ ярьж байсан бол ОУВС бол энэ бол арай эрт байна гэдгээр ярьж байсан юм. Яах вэ тухайн үед бол мэдээж нөгөө Монгол Улс ОУВС-ийн хөтөлбөрт байсан, тухайн үед Монголын арилжааны банкнууд бас тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээлтэй байсан гэдэг утгаараа активын удирдлагын компани байгуулах юм бол шууд л бараг байгуулагдсан дороо дампуурах юм биш үү. Эсхүл хувийн банкнуудад байгаа өр, авлагыг улсын активын удирдлагын компаниар худалдаж авбал энэ бас зүй зохистой мөн үү гэдгээрээ асуудал нь яригдаж байсан.*

Өнөөдөр бол манай банк санхүүгийн зах зээл өөрөө нэлээн чадавхажсан. Банкнууд бол Хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Өнөөдөр банкны чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь нийт зээлийнхээ 5,8 хувь гээд бүр маш доод түвшинд хүрсэн гэдэг утгаараа бол энэ бол яг өнөөдөр бол одоо цаг үеэ хэрвээ энэ хууль гарах юм бол яг л уг нь ямар нэг асуудалгүй байхаар боломжтой л гэж харж байгаа. Тэгэхээр хуулийн төсөл бол угаасаа тухайн үедээ бол өргөн баригдаад хэлэлцэгдээгүй учраас бол буцчихсан гэдгээр бол төсөл бол байж байгаа. Тийм.

Төсвийн орлоготой холбоотойгоор ер нь бол мөнгөний бодлого хатуу байна гэдэг маань шууд энэ М2-ын тооноос бол харагдаж байгаа байх. Хэдийгээр М2 бол 20 гаруй хувиар, 30 хүртэл хувиар өсөөд явж байгаа ч гэсэн М2-ыг өсгөж байгаа бол үндсэн юу нь бол 1 дүгээрт гаднаас орж ирж байгаа валютын урсгал байгаа. Монгол Улсын валютын нөөц түүхэн дээд

хэмжээнд хүрээд өсөөд явж байна гэдэг маань энэ М2-ын өсөлт бол тэрүүгээр тодорхойлогдож байгаа. Нөгөө талдаа банкны секторoос гарч байгаа зээл 30 гаруй хувийн өсөлттэй байна гэдэг маань дотоод цэвэр актив гэдгээрээ бас зээлийнхээ өсөлтөөр дамжаад ингээд М2 өсөөд явж байгаа. Зээл өсгөх эх үүсвэрүүд нэмэгдэж байгаа нь бол түрүүн таны хэлсэн нөгөө төсвийн, төсөвтэй төсвийн зардалтай их холбоотой хэсэг байгаа. Яагаад гэвэл төсвийн тэлэлт нь өөрөө ААН-үүдийн орлогыг нэмэгдүүлж байна. Иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмжээр дамжиж нэмэгдэж байгаа учраас банкин дахь харилцах хадгаламж жилдээ бараг 5 их наядаар ингээд өсөөд явж байгаа учраас энэ нь өөрөө зээлийн эх үүсвэр болж гараад ингээд явж байгаа.

Тэгэхээр М2 төсвийн орлогын харьцаа нь манайд өндөр байгаа нь мөнгө нь өөрөө хатуу байгаад байдаг, төсөв нь тэлээд байгаа учраас энэ харьцаа бол тэгээд хөгжингүй орнуудаас ч гэсэн илүү ингээд л болоод л явж байгаа зүйл байгаа. Тэгээд яах вэ төсвийн тэлэлттэй уялдаад банкны актив хөрөнгө бол нэмэгдэж байгаа. Нийт банкны нийт актив бол бараг 60, 66 их наяд руугаа хүрсэн. Нийт мөнгө бол өнөөдөр 42 их наяд ингээд байж байгаа.

Төлбөрийн тэнцэлтэй холбоотойгоор яг таны та бид хоёрын тоо бол нэг л байна л даа. Хамгийн сүүлд 8 сарын эцсийн байдлаар төлбөрийн тэнцэл -190 сая доллар байна. Энэ бол 190 сая долларын энэ хасах тэнцэл бол өөрөө энэ хэмжээний дараатыг Монгол Улсын валютын нөөц дээр бас үүрүүлж байгаа л гэж ойлгож…/минут дуусав/

Р.Сэддорж: *Хариултыг гүйцээж өгье, 5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Тэгэхээр төлбөрийн тэнцэл дээр бол яалт ч байхгүй арга хэмжээ авах ёстой. Тэгэхдээ төлбөрийн тэнцлийн худалдааны тэнцэл нь бол ашигтай байгаа. Үйлчилгээний тэнцэл бол алдагдалтай байгаа. Үйлчилгээний тэнцлийн алдагдал бараг 2 их наяд долларoор яригдаж байгаа. Ялангуяа Монгол Улсын ачаа тээвэр, нүүрс хэчнээн их гарч байгаа ч гэсэн нүүрсийг зөөж байгаа тээврийн компанийн 60 хувь нь гаднын компани байгаа гэдгээрээ үйлчилгээний тээврийн хөлс нь бол өөрөө шууд гадагшаа урсаад явчхаж байгаа юм. Тэгэхээр аль болохоор дотоодын экспортын энэ бүтээгдэхүүнээ гаргахдаа дотоодын тээврийн компаниуд нь явах юм бол энэ төлбөрийн тэнцлийн алдагдал бол тэр хэмжээгээр буурах боломжтой гэж бараг 5-аас 600 сая долларoор буурах боломж нь энд байна гэж Төв банкны зүгээс хараад байгаа.*

Дижитал төгрөгийн хувьд бол Монголбанк бол ерөнхийдөө судалгаа юмнуудаа хийгээд дууссан. Тэгээд олон улсын жишгээс харах юм бол CBDC буюу Төв банкны дижитал төгрөг бол өөрөө нэг бол бөөний зах дээр ажиллах тийм төгрөг байх юм уу эсхүл жижиглэнгийн зах дээр ажиллах уу гэдэг сонголтын асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр БНХАУ-ын хувьд…/минут дуусав/

Р.Сэддорж: *Батшугар гишүүн тодруулга. Цогтгэрэл дарга.*

Э.Батшугар: *Активын менежментийн компани нь мэдээж бололцоотой. Ялангуяа манай банк санхүүгийн зах зээл бол нэлээн бас томорчихсон байгаа. Үүнтэй холбоотойгоор яг байгуулагдвал яг хэдэн хувийн хүү 30 хувиар буурах уу, үгүй юу гэж асууя. Яагаад гэвэл угаасаа энэ чинь банкнууд чинь одоо бол чанаргүй зээлийн барьцаа хөрөнгөө борлуулах гэж … болохоор шүүхийн шийдвэрээр, одоо шүүхийн процессоор бараг 6-аас 7 жил явдаг, энэ эрсдэлээ өөрөө харилцагчдаа шууд зээлдэгч нартаа үүрүүлдэг. Энэ нь бол 6 хувь гэж хараад байгаа юм одоогийн байдлаар бол. Тэгэхээр миний*

түрүүн хэлсэн 18 хувийн хүү чинь 12 хувь руу буурах бололцоотой л байна л гэж харж байна л даа. Тэгээд та үүн дээр бас дэлгэрэнгүй хариулт өгчихгүй юу? Баярлалаа.

Р.Сэддорж: *5 номерын микрофон.*

Б.Лхагвасүрэн: *Батшугар гишүүний асуултад тодруулж хариулахад Монголбанкин дээр бол энэ хүүгийн түвшин, хүүгийн бүтцийг бол судалсан байгаа. Тэгэхээр нийт зээлийн хүүгийн хамгийн том байр суурь нь эх үүсвэрийн хүү байгаа, хадгаламжийн хүү гэдэг юм уу тэр нь 60 хувь. Тэгээд таны хэлж байгаа тэр банкны ялангуяа энэ муу активтай холбоотой зардлын хэсэг нь бол ерөнхийдөө 17, 8 хувь гэж яригддаг юм. Банкны өөрийнх нь урсгал зардал нь бол 12, 3 хувь, дижитал буюу технологийн шинэчлэлд зарж байгаа нь бас 17, 8 хувьтай гээд ингээд нийтдээ ерөнхийдөө зээлийн энэ бүтэцтэй. Тэгэхээр ямар ч байсан бол 20, 20 орчим хувиар буух л боломжтой гэж харж байгаа юм. Активын удирдлагын компани бол ерөнхийдөө бол ингээд муу активаа зарж борлуулаад явах боломжтой болно. Дээр нь нөгөө барьцаа хөрөнгө байгаа банкны актив өөрөө эдийн засгийн эргэлтэд ороод явна. Өнөөдөр бол энэ нийт чанаргүй болсон зээлүүд бол дандаа шүүхийн маргаантай, шүүх дээр хамгийн дунджаар 5 жил гээд, хамгийн ихдээ 7 жил хүртэл…/минут дуусав/*

Р.Сэддорж: *Баярлалаа. Ганзоригийн Лувсанжамц гишүүн.*

Г.Лувсанжамц: *Энэ өдрийн мэндийг хүргэе. Мөнгөний бодлогын төслийн ер нь бол орон сууцын ипотекийн зээлийн хэсэг дээр их анхааарч уншлаа. Тэгээд энэ жилээсээ, ирэх жилээс эхлээд Хуримтлалын сан болон Монголбанк дээрээс нь нэмээд хувийн банкнуудтай нийлээд 1,2 их наядын ипотекийн санхүүжилтийг хийнэ гэж байгаа нь их дажгүй тоо гэж санагдаж байна. Цаашдаа бас жигд авч явж байгаа гэдэг зорилтыг их таашааж байна. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр 2028 он хүртэл 1.1.3 дээр ипотекийн зээлийн 50-аас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно гэсэн зорилт байгаа, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 3.1.4 дээр бас адилхан. Ипотекийн зээлийн 50-аас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно гэсэн.*

Сая Батнайрамдал гишүүн бас хэлсэн. Одоогийн нөхцөл байдалд харж байхаар 40 хувь нь Хан-Уул дүүрэгт буюу 2 гүүр даваад, ерөөсөө ингээд мөнгөтэй, орлого өндөртэй хүмүүст зориулсан л зээлийн ийм сонголт олгогдоод байна гэсэн тийм нөхцөл байдал харагдаад байна л даа. 94 дүгээр хуудаснаас харахад бол энэ онд олгосон нийт зээлийн өрхийн, зээлийн өрхийн тоогоор нь хараад үзэхээр орон нутагт орон сууц худалдан авч байгаа 3,3 мянган өрх буюу нийт олгосон зээлийн өрхийн тооны 50 хувь нь орон нутагт олгож чадаад байна шүү дээ тийм ээ. Тэгэхээр нөгөө байршлын хувьд ипотекийн зээлийг орон нутагт олгож чадаж байгаа юм чинь Улаанбаатар хотод ч гэсэн яг энэ бодлогыг хэрэгжүүлээд ЗГ-ын энэ зорилт, зорилгуудыг дэмжиж ажиллах тийм талаас нь хийгээсэй гэж хүсэж байна л даа. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А/246 дугаар тушаалаар баталсан ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зээл олгох түр журам гэж байгаа. Үүгээр зохицуулж байгаа болов уу гэж би таамаглаж байна. Энэ зөв үү гэдэг 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарх нь яг энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжээд, ялангуяа гэр хорооолд байгаа бага, дунд орлоготой иргэдэд орон сууцын зээл авах боломж буюу affordable housing гэдэг тийм ээ орлогод нийцсэн орон сууц. Яг үнэнийг хэлэхэд ингээд 2 гүүр даваад нэг хүн байр авсны оронд гэр хорооллын дэд төвүүд дээр хэрэгжих төслүүд дээр зээл

олгох юм бол 2 өрх авах боломжтой болж байгаа. Энийг хэрэгжүүлэх үү гэдэг эхний асуулт байна.

2 дугаар асуулт болохоор ипотекийн зээл авах гээд хүсэлт гаргахаар очер дараалал маш их байгаа. Олон улсад орон сууцын бодлого дээр яаж үздэг вэ гэхээр ингээд хэрвээ 2-оос дээш хүүхэдтэй, 3-аас дээш хүүхэдтэй байх юм очер дараалалгүйгээр хамгийн тэргүүн ээлжид ипотекийн зээл авах боломжийг нь шууд тэргүүн ээлжид шийдэж өгдөг. Монгол Улсын хувьд ч гэсэн хэрвээ 2-оос дээш хүүхэдтэй тийм өрхүүд ипотекийн зээл авъя гэсэн хүсэлт гаргах юм тэргүүн ээлжид тэдгээрийн асуудлыг нь шийдэж өгдөг ийм шинэчлэлүүдийг энэ журмаа шинэчлэхдээ цуг оруулж ирэхийг хүсэж байгаа болохоор ийм ажлуудыг хийх үү гэдэг тодорхой асуултыг асууж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: *5 номер хариулт.*

Б.Лхагвасүрэн: *Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тийм. Монголбанк энэ 2013 оноос хойш энэ ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Гэхдээ Төв банкны хууль дээр бол өөрөө энэ ямар нэг салбар ААН, хувь иргэнийг дэмжсэн ийм мөнгөний бодлого, ийм зээл бодлого байх ёсгүй гэдгээрээ бол ерөнхийдөө энэ ипотекийн зээлээс бол Монголбанк бол ерөнхийдөө хуулиараа бол гарах ийм шаардлагатай болчхоод байгаа юм. Тэгэхдээ өнгөрсөн онд баталсан Улсын Их Хурлын тогтоолын дагуу бол ЗГ-т шилжүүлтлээ энэ хөтөлбөрийг өөрөө авч явж байгаа. Энэ хөтөлбөрийг нэгэнт Монголбанк авч явж байгаа гэдгээрээ бол яг манай наад дотоод журам бол үйлчилж байгаа.*

Өнгөрсөн оны Улсын Их Хурлын тогтоол гарахдаа хот, хөдөөд тэнцвэртэй олго гэж гарсан учраас энэ жилийн зээлүүд бол яг тэгж тэр зорилгоор ингээд яваад ямар ч байсан хэрэгжээд үр дүнд хүрээд явж байна. Таны тавьж байгаа саналын дагуу ялангуяа Улаанбаатар хотдоо зах хороолол руу гэдэг талаас нь бид нар ажлын хэсэг гараад Барилга, хот байгуулалтын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эд нартай ажиллаад явж байгаа юм. Тэгэхээр аль болохоор хүүгийн хөнгөлөлт нь бол тэр зах хороолол руугаа илүү байна, илүү тийшээ чиглүүлье гэж байгаа юм. Тэгээд бас Ганхуяг гишүүний түрүүн бас асуусан тэр нөгөө эрчим хүчний хэмнэлттэй хувийн орон сууц гээд, тэрийг ипотекийн хөтөлбөрт ингээд оруулж ирж байгаа учраас ялангуяа тэр хашаа гээд нөгөө газартай, өөрийн газартай, тэрэн дээрээ хувийн орон сууц барих гэж байгаа иргэдэд энэ зээл нь олгогдоод явах учраас бол яг таны хэлж байгаа саналын дагуу бол тэр лүүгээ бол бас илүү их хандаад явах байх гэж харж байгаа юм.

Зүгээр 2-оос илүү хүүхэдтэй ялангуяа тэр очерын урдуур орох боломжтой гэдгээрээ бол ер нь бол энэ нийгмийн хариуцлага талаасаа ч гэсэн энэ бол маш зөв санал л гэж харж л байна л даа. Тэгээд арилжааныхаа банкнуудтай уулзаж яриад аль болохоор энийг нөгөө заавал журамлах ёстой юу эсхүл нөгөө Монголбанк, арилжааны банк 2 эх үүсвэр яахдаа нөгөө гэрээ байгуулдаг юм эх үүсвэрийн. Тэр гэрээндээ тусгаж өгөх ёстой юу гэдэг дээр нь ярьж байгаад танд хариу өгье.

Р.Сэддорж: *Тодруулга байгаа юу? Баярлалаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.*

Л.Соронзонболд: *1 асуулт байна. Зээлийн хүүг бууруулах стратегийн зорилт гээд бид нар 2018 онд Улсын Их Хурлаас баталсан. Тэгээд өнөөдөр бас Монголбанк маань мөнгөний бодлогын хүүгээ бууруулаад 10 хувь болгосон байгаа, эдийн засгаа дэмжих бодлого баримталж байна гэж үзэж байгаа. Гэтэл өнөөдөр зүгээр сүүлийн үеийн мэдээллээр бол төгрөгийн заавал байлгах*

нөөцийг 8 хувь байсныг нь 10 хувь болгож өсгөсөн гэж би сонслоо л доо. Тэгэхээр эргээд нөгөө зээлдэгчид очиж байгаа зээлийн хүү маань өсөх гээд байна уу даа, энэ дээр яг жоохон бодлого зөрчилтэй байна уу гэж ойлгоод байгаа юм. Тийм учраас энэ дээр тайлбар хүсэж байна.

Р.Сэддорж: *5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Түрүүн бас Батнайрамдал гишүүн бас хөндсөн. Тэр ОУВС-ийн зөвлөмж гэдэг юм уу, саяын ирсэн багийн тодорхой хэмжээний зөвлөмж дотор бол 25 оны төсөв тэлж байгаа, дээр нь бол тодорхой бус байдлууд нэлээн байгаа учраас бол Монголбанк бол мөнгөний бодлогын төлөвөө сулруулах энэ арга, хийж байгаа алхмууд дээрээ бас нэлээн хянуур байгаарай гэсэн маягаар зөвлөгөө өгсөн байгаа. Тэр утгаараа ч тэр бодлогын хүү хэдийгээр 10 болсон ч гэсэн нөгөө талдаа бас нөгөө тодорхой хэмжээний хяналт байна гэдэг макро зохистой бодлогын арга хэмжээг бол авч хэрэгжүүлсэн нь тэр саяын заавал байлгах нөөцийн хувийг 8 байсныг 10 болгосон байгаа. Яах вэ энэний үр дүнгээр үр дүн бол өөрөө бол яг одоогоос эхлээд гараад эхэлж л байна л даа. Энэ нь өөрөө юу байна вэ гэхээр манай нөгөө илүүдэл нөөц бол буураад явж байгаа. Түрүүн 10 их наядаар хэмжигдэж байсан үнэт цаас бол 8,7 их наяд болж буураад явж байгаа.*

Тэгэхээр бол заавал байлгах нөөцийг нэмсэн арга хэмжээ маань илүүдэл нөөц дээр л тавигдсан арга хэмжээ болохоос биш яг нөгөө бизнесийг дэмжиж байгаа зээл ч гэдэг юм уу, ЖДҮ-ийг дэмжиж байгаа зээлийнх нь эх үүсвэрийг бол татна гэж ерөнхийдөө Монголбанкны зүгээс бол бас яг тэгж харахгүй байгаад байгаа. Зүгээр нэгэнт ЗГ-аас өөрөө түрүүн бас олон хөтөлбөрүүд байгаа л даа. Хүнсний хувьсгал ч гэдэг юм уу, хоршоог дэмжих зээл ч гэдэг юм уу ингээд хүүгийн татаастай буюу хүүгийн хөнгөлөлттэй үзүүлж байгаа зээлүүд нь өөрөө тэртээ тэргүй банкны эх үүсвэрээр яг хүү нь өөрөө яг зээлдэгч л төлж байгаа хүү нь бага болохоос биш яг дундаж хүү бол өөрөө 18 хувиар гараад явж байгаа учраас энэ дээр бол бас нөлөөлөл бага болов уу л гэж л Монголбанк тэгж л харж байгаа.

Р.Сэддорж: *Тодруулга байгаа юу? Баярлалаа. Бадрахын Найдалаа гишүүн.*

Б.Найдалаа: *Баярлалаа. 2025 оны хөгжлийн төлөвлөгөө дээр нэг зүйл дээр гадаадын банк оруулна хариуцах эзэн Монголбанк гээд тавьчихсан байна лээ л дээ төсөл дээр нь. Энэтэй холбоотой бас яг энэний энэ бичиг баримтын 2.1 дээр банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэх зохицуулалтыг нэмэгдүүлэх, зохицуулалтын орчныг бүрдүүлнэ гэчихсэн байна. Тэгээд зүгээр сонирхож байгаа юм яг одоогийн байгаагаасаа гадаадын хөрөнгө оруулалт гадаадын банкийг оруулахад чиглэсэн ямар жишээ нь зохицуулалтын ажлыг хийх вэ? Нэг асуулт.*

2 дахь нь нэг ийм түгээмэл ойлголт байна. Гадаадын банк орчихвол зээлийн хүү шууд буурчих юм шиг. Яг судалгаа дээр тийм байна уу, байхгүй юу. Энэ баримт бичиг дотор бас судалгаа байна лээ л дээ. Би сайн ойлгосонгүй. Хэрвээ гадаадын хувь эзэмшил нэмэгдэх юм бол хувийн секторын ДНБ буурна гэсэн судалгааны дүн байх шиг байх юм. Тэгээд та бүхэн маань яг энэ дээр олон жил тоог нь харж байгаа, судалгаа хийж байгаа хүмүүс тодорхой шууд хэлж өгөөч. Гадаадын банк орж ирснээр зээлийн хүүд яг яаж нөлөөлөх юм бэ, буурах юм уу, буурахгүй юм уу? Энийг тодорхой хэлэхгүй ийм үл ойлголцол хоосон төөрөгдөл байх шиг байна.

Дараа нь хэрэглээний зээл буурсан байна. 2008 онд, 18 онд 36,2 хувь байсан юм байна, 22 онд 26 хувь болж буурсан байна л даа. Тэгээд энэ нөгөө өрхийн орлогын хязгаар тавьсны зохицуулалтын

үр дүн байх. Гэхдээ энэ яг банкны салбарын дүн үү, нийт санхүүгийн салбарын Монгол Улсын дүн үү? Энэ маш сонирхолтой байна. Хэрвээ ингээд банкны салбар дээрээ зохицуулалтаа хийгээд хамаг зээлээ иргэдийнхээ санхүүгийн хэрэгцээг нь банкнаас гадуур гаргаад нөгөө өдрийн зээл, банк бус санхүү, өөр юу байдаг юм бусад салбар луу гаргаад, тэрэнд нь өндөр хүүтэй, илүү эрсдэлтэй, илүү ачаалалтай зээлд оруулчхаад байгаа юм биш биз дээ?

Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарын зохицуулалтыг 2 газар хийгээд байгаа байхгүй юу. Нэг тоог 2 талаас нь хутгаад байгаа юм СЗХ, Монголбанк 2. Тэгээд энэ 2 ингээд уялдахгүй бол наанаа ингээд тоон дээрээ гоё юм шиг харагдаж байгаа боловч цаанаа яг бодит байдал дээрээ зах зээлээ алаад байгаа юм биш үү? Энэ дээр тодорхой хариулт өгөөч?

Бас нэг асуулт байна. Их өгөгдөл ашиглана гээд нэг ийм том өгүүлбэр байна. Их өгөгдөл гэж яг юуг хэлээд байна вэ? Монголбанкны нөгөө хуулиар заасан үүрэг гүйцэтгэхэд энэ яг ямар хамааралтай билээ? Яг юу билээ? Тодруулж өгнө үү.

Хамгийн сүүлийнхэд нь төсвийн тэлэлт бол яах аргагүй мөнгөний бодлогод нөлөөлж байгаа, орон зайг нь хумьж байгаа, энийг бол бүгдээрээ мэдэж байгаа байх. Та бүхэн бас судлаачид байна. Монголбанк хараат бус байгууллага энэ байр сууринаасаа яг орон зайг нь хэр хумьж байгаа вэ? Уг нь бол мөнгөний бодлого хувийн хэвшлийг дэмжихэд илүү нөлөөтэй байхгүй юу. Тэгэхээр яг энэ орон зайг нь хумьчхаад байгаа юм биш үү? Энэ дээрээ бас өөрсдийнхөө байр суурийг хэлээч? Баярлалаа.

Р.Сэддорж: *Хариулт хэн бэ? 5 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч.*

Б.Лхагвасүрэн: *Найдалаа гишүүний асуултад шууд хариулахад бол гадаадын банк орсон ч бай, ГХО орж ирсэн ч бай угаасаа энэ Монгол Улсын энэ санхүүгийн зах зээлд бол угаасаа энэ зах зээлийн л нөхцөл үйлчилнэ л дээ. Тэгэхээр өнөөдөр ингээд төгрөгийн хүү бодлогын хүү маань 10 хувь, ингээд банкнуудын татаж байгаа эх үүсвэрийн хүү бол хадгаламж гэхэд чинь 12 хувь ч юм уу, тэгээд дундаж зээлийн хүү 18 гээд энэ нөхцөлүүд нэгэнт байгаа учраас гаднын банк орж ирээд энэ нөхцөлөөс бол жоохон бага байх л өрсөлдөөн гэдгээрээ бага байх л багасгах, бага зэрэг л бага байх л тийм үйлчилгээ санал болгох л байх л даа. Тэрнээс биш бүүр шууд доошоо огцом буугаад, тэр дэлхийн зах зээлийн хүүтэй адилхан хүү болно гэдэг бол тийм байх боломж байхгүй л гэж хэлж байгаа юм.*

Жишээлбэл өнөөдөр АНУ-ын бодлогын хүү бол 4,75-аас 5,25-ын хооронд ингээд байж байгаа юм. Тэгээд энэ хүү бол өнөөдөр тэнд л байгаа хүү. Тэгээд энэ нь бол суурь хүү. Тэгээд энэ дээрээ эрсдэлийн жингээрээ нэмэгдээд Монгол Улсад бол орж ирэхдээ бол заримдаа 2 оронтой тоо болж орж ирдэг. Заримдаа ингээд 8, 9 хувьтай, манай хамгийн сүүлийн гаргасан ЗГ-ын бонд ч гэсэн энэ хэмжээнд байх жишээтэй. Тэгэхээр нэгэнт л ингэж орж ирэх юм чинь ийм валютын хүү бол угаасаа Монгол Улсад ч гэсэн байж байгаа. Манай арилжааны банкнуудын өнөөдөр зээлийн валютаар олгодог зээлийн хүү чинь бас л нэг энэ орчимд л байгаа шүү дээ. Тэгэхээр бол энэ дээр бол нэг их тийм зарчмын огцом буурсан ийм нөлөө үзүүлэх бол тийм боломж нь бол хомс л гэж л Төв банкны зүгээс бол харж байгаа юм.

Хэрэглээний зээлийн хувьд бол таны асуусан тоон дээр энэ бол зөвхөн манай банкны салбарын тоо байгаа. Тэгэхээр бол ер нь бол банк бусын тоо бол маш огцом өсөлттэй байгаа. Ер нь өсөлт нь бол бараг нэлээн ийм дээшээ маягийн ийм огцом, налуу ч биш, огцом дээшээ ийм маягийн юм байгаа. Тэгээд

Монголбанкны зүгээс бол стандарт энэ юугаа нөхцөлөө адилтгаад ижилхэн байя гэдэг саналыг бол тавьсан. Тэгээд СЗХ-ноос удахгүй хэрэглээний зээлийн нөхцөлүүдийг хатууруулна гэдэг ийм албан тоот ирсэн учраас бол удахгүй арга хэмжээ авах байх гэж харж байгаа.

3 дахь асуултын хувьд бол их өгөгдөл буюу тэр bigdata гээд Монголбанкин дээр нэг тийм төсөл хэрэгжүүлж байгаа. Ялангуяа энийг бол тэр ногоон чиглэл рүү хийж байгаа. Өнөөдөр бол Монгол Улс бол ингээд ногоон бонд гаргаж байна, олон улсын санхүүгийн байгууллагуудаас бол ногоон бизнест зориулж зээл эх үүсвэр татаж ирж байна. Тэгээд эргээд тайлангаа тавих үед бол энэ үнэхээр ногоон зориулалттай бизнест олгосон уу? Энэ тайлангийн асуудал маш хүнд байгаа. Энэ тайланг баталгаажуулах асуудлууд нь ингээд хүнд байгаа. Тэгэхээр ямар ч байсан эхний ээлжид бол датагаа их өгөгдөл маягаар бүх тоон мэдээлэл, тайлангуудаа нэгтгээд авчихъя Монголбанкин дээрээ. Дараа нь энийгээ нөгөө анализ дүн шинжилгээ хийнэ, дараа нь энийгээ баталгаажуулдаг ялангуяа олон улсын хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулаад. Тэгээд цаашдаа бол нөгөө хүлэмжийн хий бууруулах тал руу нь, нүүрсхүчлийн хийн нөгөө арилжаа гэдэг юм уу тэрэн дээр хүртэл зах зээлийг бий болгох тал руу нь ажиллахаар энэ их өгөгдлийг бол ингээд хийгээд явж байгаа юм.

Р.Сэддорж: *Тодруулга байна уу? Найдалаа гишүүн тодруулга.*

Б.Найдалаа: *2 зүйл зүгээр орхигдох шиг боллоо. Нэг нь тэр нөгөө гадаадын хөрөнгө оруулалтыг банкны салбарт нэмэхэд зохицуулалтын орчныг сайжруулна гэсэн маягтай юм байсан. Энэ яг тийм юм байгаа юу гэдэг байна. Яг юу хийх юм бэ, хийхээр юм байгаа билүү, байхгүй билүү?*

2 дахь нь зүгээр төсвийн тэлэлт бол ингээд тэлж байгаа нь ойлгомжтой. Тэгээд Монголбанк хараат бус байгууллага юм чинь яг мөнгөний бодлого явуулах орон зай байна уу, байхгүй юу? Эсвэл байхгүй болохоор зүгээр хатуу бодлого явуулахаас ямар ч өөр ямар ч хувилбаргүй. Өөрөөр хэлбэл бид нар өнөөдөр ямар ч сонголт биш зүгээр л явуулахаас өөр аргагүй бодлогыг л ярилцаад, хэлэлцээд, батлаад сууж байгаа юм шиг сэтгэгдэл төрөөд байна л даа. Та бүхэн юу гэж бодож байна вэ?

Р.Сэддорж: *5 номер.*

Б.Лхагвасүрэн: *Найдалаа гишүүний асуултад тодруулж хариулъя. Тийм, хууль эрх зүйн орчны хувьд бол өнгөрсөн жилээс эхлээд ингээд сайжруулаад явж байгаа. Жишээлбэл гадна үйл ажиллагаа явуулдаг гадаадын арилжааны банк Монгол Улсад орж ирэх юм бол бид нар дүрмийн сангийн доод шаардлага гэдэг юмыг тавихгүй. Тэгэхээр бол өнөөдөр арилжааны банкны дүрмийн сангийн доод шаардлага бол 100 тэрбум төгрөгтэй байж банкны үйл ажиллагаа явуулж байгаа бол гаднын арилжааны банкны салбар орж ирэхэд энэ дүрмийн санг бол шаардахгүй гэдэг. Энэ бол маш ийм зөөлөн уян хатан зүйл байгаа.*

Нэг зүйл нь гэвэл түрүүн би бас Ганхуяг гишүүний асуултад хариулж байхдаа хэлж байсан. Тэр олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсын банканд хөрөнгө оруулалт хийхэд нь тэр нэг банкны хяналтын багцыг авсан хувьцаа эзэмшигч нөгөө банканд орж болохгүй гэдэг энэ хуулийн заалтыг хэрвээ өөрчилж өгөх юм бол тухайн хөрөнгө оруулагч нар бол ингээд нээлттэй орж ирэх боломж нь ингээд бүрдэж гарч ирэх юм. Тэгэхээр энэ заалтуудыг өөрчлөхөөр ингээд тусгасан байгаа.

Төсөв угаасаа тэлэлттэй байгаа учраас Монголбанкинд бол ер нь

мөнгөний бодлогыг тэлж, Монголбанк өөрөө хөнгөлөлттэй эх үүсвэр гаргах орон зай бол байхгүй л гэж ойлгож болно.

Р.Сэддорж: *Баярлалаа. Баатаржавын Мөнхсоёл гишүүн.*

Б.Мөнхсоёл: *Хамгийн сүүлийн хүн байна уу? Бараг зарим асуултууд нь тэгээд давхцаж байх шиг байна. Зүгээр давхцуулахгүй 3 асуулт асуучихъя гэж бодож байна. Би болохоор тэр ипотекийн зээлтэй холбогдуулаад бараг эсрэг гэх юм уу байр суурьтай байгаа. Өөрөөр хэлбэл 2017 оны ОУВС-ийн өгсөн зөвлөгөөний дагуу уг нь холбогдох яаманд нь ипотекийн зээлийг шилжүүлэх гээд чадахгүй яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг дахиж хөндмөөр байна. Өөрөөр хэлбэл Монголбанкны бие даасан байдал дээр нэг тавигдаж байгаа асуудал л нь юу вэ гэхээр ЗГ-аас авах авлагын хэмжээ нь өсөөд байгаа байхгүй юу. Одоо -4 их наяд төгрөг гэж харагдсан. Тэгэхээр энэ талаар энэ дүнг харахаар нөгөө бие даасан байдал чинь хангагдаж чадаж байна уу гэдэг одоо хүртэл мэдсээр байгаа тэгсэн мөртөө ипотекийнхээ зээлийг шилжүүлж чадахгүй ийм асуудал байгаа. Энийг хариулт авъя.*

2 дугаарт нь ажлын байр нэмэгдүүлэхтэй холбогдуулаад 2021 онд 10 их наядын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн. Энэ 24 оны мөнгөний бодлогын гүйцэтгэл дээр байна шүү дээ. Тэрэн дээр ерөнхий мэдээлэл байна. Ажлын байр нэмэгдүүлэхийн тулд энэ 10 их наядыг жижиг, дунд үйлдвэрлэлд зээлсэн гээд. Тэгээд тэрний үр дүн ямар байдалтай байгаа вэ? Тэр тухайн үедээ нэг ганц, хоёр жил жоохон мэдээллээр хангадаг байсан. Одоо бүүр таг болсон. Тэгэхээр яг үр дүн хэчнээн ажлын байр бий болсон юм, хөнгөлөлттэй зээлийн өгөөж нь юу байв гэж асуумаар байна.

Энэ Шинэ хоршоо гээд хөтөлбөр хэрэгжиж байна. Нөгөө талдаа малчны зээлийн үлдэгдэл 1,3 их наяд төгрөг байна. Тэгэхээр энэ Шинэ хоршоо хөтөлбөрөөр зээлийг арилжааны банкнуудаар мэдээж дамжуулах байх л даа. Тэгэхээр гол шалгуур үзүүлэлт нь юу вэ? Санаа зовж байгаа нэг зүйл бол малчид бас өр зээлд унах вий. Нөгөө өртэй Монгол гэдэг дээр нэмэгдэх ийм хүчин зүйл болчих вий гэсэн ийм санаа зовж байгаа зүйл бас байгаа юм. Энэ 3-ыг л асууя.

Тэгээд би энэ Найдалаа гишүүний асуулт дээр зүгээр нэмээд зүгээр ту с… гэдэг шиг олон жил ярьж байгаа шүү дээ. Оруулна, оруулахгүй, гаднын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай банкийг, гаднын хөрөнгө оруулалттай банкийг дэмжье гээд. Одоо энэ танай энэ мөнгөний бодлогын чиглэлийн баримт бичиг дээр бас зүгээр нэг салбар оруулж ирэх төдий, тэрнээс биш яг ийм хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлсэн тийм бодитой ийм юу гарч ирэхгүй байна гээд байгаа шүү дээ сонирхсон этгээд. Тэгэхээр энэ нөгөө хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна гээд та нар яг ямар өөрчлөлт оруулаад, ямар төрлийн, хэр дунд, том хэмжээний банкны салбар орж ирэх боломжтой гэж бодитоор харж байгаа вэ? Энэ одоогийн байдлаар бол 20 хувь хүртэлх ч гэдэг юм уу арилжааны банкны хувьцааг авах эсвэл салбараа байгуулах энэ тэр 3 төрлийн ийм боломж байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр бодит байдал дээр яг яаж харж байгаа вэ л гэж, бодит байж чадах уу л гэж асуумаар байна. Ингээд 4 асуулт асуучихъя. Баярлалаа.

Р.Сэддорж: *5 номер. Бусад энэ номерын хүмүүсээс бас асуулт асуугаарай гишүүд.*

Б.Лхагвасүрэн: *Мөнхсоёл гишүүний асуулт дээр тийм манай газрын захирлууд бас нэмээд хариулчих байх. Ипотекийн энэ зээлийг хөтөлбөрийг ерөнхийдөө ЗГ-т шилжүүлье гэдэг нь бол зарчмын хувьд шийдэгдчихсэн зүйл. Тэгээд Барилга, хот байгуулалтын яам дээр Үндэсний орон*

сууцын корпорацын тухай хуулийг бол санаачлаад явж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ хууль хэрвээ батлагдаад манай хөтөлбөрийг шилжүүлж авах байгууллага нь гараад ирэх юм бол ингээд шилжүүлэхэд бэлэн байгаа. Тэрнээс өмнө бол мэдээж энэ хөтөлбөрийг бол үр дүнг нь хадгалаад явах нь бол Монголбанкны үүрэг гэдгээрээ ингээд аваад явж байгаа юм. Тэгэхээр бол энэ бол ингээд шилжих нь бол тодорхой болсон гэж ийм хариулт байгаа юм.

Ажлын байр дэмжих, тухайн үеийн 2022 оны тэр 21 оны ЗГ-ын тэр анхны энэ хөтөлбөр бол ерөнхийдөө амжилттай хэрэгжээд дуусан. Ялангуяа тэр ажлын байр дэмжих гэдэг дээр нь 2 их наядын зээл гарсан. Өнөөдөр хамгийн сүүлд авсан манай тайлангаар бол 11 тэрбум төгрөгийн зээл л үлдсэн байна лээ. Тэгэхээр бол ерөнхийдөө бүрэн төлөгдөж дуусан гэж ойлгож болохоор байгаа юм.

Малчны зээл, хоршоолол хоршооны зээлтэй холбогдуулаад яах вэ энэ онд нөгөө энэ хавар малчны хүнд нөхцөл байдалд зуд болсон. Тэр утгаараа 8,1 сая мал хорогдсон гэдэг ийм тоо мэдээ явж байгаа. 1,3 тэрбум төгрөгийн малчны зээл байгаа. Энэ зээл дотор бол мэдээж 1,3 их наядын зээл, мэдээж яг тэр зуд болсон хэсэг буюу тэр 8 аймаг байгаа. Тэр 8 аймаг дээр бол мэдээж асуудал үүсэж байгаа малчны зээлтэй холбогдуулаад. Тэгээд Монголбанкнаас бол ерөнхийдөө зохицуулалтын хувьд бол чөлөөлж өгч байгаа. Чөлөөлөх гэдэг маань зээлээс нь чөлөөлж байгаа биш, төлөх хугацааг нь хойш нь ингэж нөгөө зохицуулалттай зөөлрүүлж өгсөн гэж ойлгож болно. Тэгэхээр 1 жилийн дараа төлөхөөр хугацааг нь бүтцийн өөрчлөлт хийгээд ингээд арга хэмжээ ингээд аваад явж байгаа. Сүүлийн үед хоршоогоор авч байгаа зээлтэй холбогдуулаад бас тэр өмнө нь малчны зээлтэй иргэдээс бас нэг санал хүсэлт ирж байгаа. Яагаад гэвэл өмнө нь авчихсан зээлээ дахин санхүүжүүлэх маягаар энэ хоршооны зээл авч болох уу гэдэг санал байгаа. Тэр саналыг нь бол дэмжээд явж байгаа. Тэгэхээр хоршооны зээл авч байгаа малчид дээрээ саяын энэ өмнөх зээлээ дахин санхүүжүүлэх маягаар аваад явах юм бол илүү бүр илүү хялбар болно л гэж ойлгож байгаа. Тэгээд энэ талаар ингээд ажиллаад явж байгаа юм.

Хамгийн сүүлийн асуулт нь юу билээ? Ерөнхийдөө яах вэ зүгээр гаднын хөрөнгө оруулагчидтай банкнуудтай уулзалт бол хийж байгаа. Тэгээд уулзалт хийх явцад бол тэдний зүгээс ер нь бол ийм л санал тавьдаг юм. Бид нар Монгол Улсад, Монголын бас банк санхүүгийн салбарт хэрвээ хөрөнгө оруулаад орж ирэх юм бол хамгийн түрүүнд бид нарын бодох толгойд орох бол буцаад гарахдаа яаж гарах вэ л гэж байгаа юм. Тэгэхээр энэ талаар ямар нэг зүйл байна уу гэж байгаа юм. Тэгэхээр мэдээж манай банкнууд Хөрөнгийн биржид листэд болоод ингээд хувьцаа нь чөлөөтэй арилжаалж байгаа учраас хувьцаа авчихсан хүн бол Хөрөнгийн биржээр буцаад зарах юу нь нээлттэй байна гэж байгаа юм. Өөр нэг тавьдаг хамгийн том зүйл нь бол хөрөнгө оруулагчдыг яаж хамгаалах юм бэ л гэдэг юм. Тэгэхээр бол зөвхөн банканд зориулж тусгайлан хамгаалалт гэж яригдахгүй байх. Их Хурал дээр нөгөө…/минут дуусав/

Р.Сэддорж: *Гүйцээж хариулах уу? 5 номер гүйцээж хариулъя.*

Б.Лхагвасүрэн: *Тэгэхээр Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр гаднын хөрөнгө оруулалтыг яаж хамгаалах вэ гэдэг заалтууд орж ирэх юм бол мэдээж нийтлэг маягаараа тэр нь ингээд явах байх гэдгээрээ ярьж байгаа.*

Өөр нэг зүйл нь гэвэл таны хэлж байгаа тэр нэг хувь эзэмшилтэй холбоотой зүйл байгаа юм. Тэрэн дээр жоохон маргаан бас төвөгтэй зүйлүүд байгаа. Тэрэн дээр юу яригдаж байна вэ гэхээр 34 хувь гээд танай Компанийн тухай хууль дээр бол ийм заалт байна.

Тэгэхээр 34 хувь гэдэг ийм заалт байсаар байтал энэ 20 гэдэг тоо чинь бас ямар учиртай тоо вэ л гэж л яриад байгаа юм л даа. Тэгэхдээ нэгэнт энэ хууль байгаа учраас бол хуулиа л тайлбарлалаа. Тэгээд ер нь бол жижиг банканд бол ийм жижигхэн хувиар орж ирэх нь бол сонирхолгүй байна. Том банканд бол болж байна. Жижиг банк чинь энд чинь хамаарч байгаа нь өөрөө бас төвөгтэй байна л гэдэг л тийм л зүйлүүд л бас л тавиад байгаа юм.

Р.Сэддорж: *Тодруулга яасан билээ? Байхгүй, болчихсон байна. Алтаншагай гишүүн байна уу? Алга байна. Соронзонболд гишүүн асуулт асуух уу? Байхгүй байна. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дуусла. Төсөлтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирсэн саналаар санал хариулт явуулъя. Цуг явчихсан.*

Тогтоолын, 1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд. 1 дүгээрт. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3 дахь бүлэгт доор дурдсан агуулгатай шинэ заалт нэмэх:

3.5.Гар утсанд суурилсан төлбөрийн картын болон олон улсын цахим худалдааны системүүдийг Монгол Улсад амжилттай нэвтрүүлэх хүрээнд банк санхүүгийн байгууллагыг дэмжиж ажиллах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалтыг явуулъя. Энэ томьёоллоор дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Санал дэмжигдсэнгүй. 12,5 хувиар санал дэмжигдсэнгүй. 2, саяынх бол байгаа юм байна. 3.1 дээр 3 байгаа юм байна. Тийм.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 4 дүгээр бүлэг шинээр нэмэх.

4 дүгээр бүлэг.Орон нутаг дахь жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд.

4.1.Орон нутагт олгосон бизнесийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 75 болгож бууруулах;

4.2.Орон нутагт бизнесийн зээл болон хэрэглээний зээлийн зохистой харьцааг боловсруулж, арилжааны банкаар мөрдүүлэх;

4.3.Орон нутаг дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгож байгаа зээлийн хүүгийн хувь хэрэглээний зээлийн хүүгээс бага байх бодлогыг хэрэгжүүлэх;

4.4.Зээлийн батлан даалтын сангийн баталгаа зээлийн даатгалын болон бусад хэлбэрээр орон нутагт бизнес эрхлэгчдийн бизнесийн зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулахад дэмжлэг үзүүлэх бодлогын арга хэмжээ авах;

4.5.Бизнесийн зээлийн үйл ажиллагааны үе шат бүрийг 100 хувь дижитал шилжилт хийсэн тохиолдолд эрсдэлээр жигнэх хувийг бууруулах болон бусад бодлогын арга хэрэгслээр дэмжих. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд. Асуулт асуух юм уу? Гишүүн гишүүн саналаа тайлбарлаж болно. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: *Бид саяхан 2024-өөс 2028 оны ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд баталсан. Тэгээд Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх бодлого, хөдөөгийн сэргэлт, төвлөрлийг бууруулах гээд ийм бодлогууд баримталж байгаа. Энэ хүрээндээ бас энэ ялангуяа хөдөө орон нутагт бизнес эрхэлж байгаа бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгыг бодлогын арга хэмжээ оруулах нь зөв юм болов уу гэж бодож энэ саналыг гаргасан. Яагаад вэ гэхээр орон нутгийн арилжааны банкнуудын нэгдсэн тайлан тэнцлийг*

харахаар балансын зээлийн багцынх нь бүтэц нь бол хэрэглээний зээл нь илүү давамгай байна уу даа гэж харж байгаа.

Нөгөө талдаа болохоор бол мэдээж арилжааны банкнууд бас үйл ажиллагааны стратеги энэ тэрээ бодолцож үзэхээр суманд бол 2-оос 3 хүнтэй салбар ажиллуулж байгаа. Тэгэхээр 2-оос 3 хүнтэй салбар болохоор бол тухайн бизнесийг ойлгож дэмжих тал дээр бол бодлого дэмжих талаасаа бол их тийм юу муутай байна гэж харж байна, дэмжлэг муутай байна гэж харж байгаа. Тийм учраас бол ер нь орон нутагт бизнес эрхлэгчдийг дэмжих талаас нь бол энэхүү саналыг бол зориуд тусгаж гаргаж ирсэн юм. Энийг бол мэдээж Монголбанк бол бас тодорхой хэмжээнд бодлогынхоо, өөрийнхөө харьцаа үзүүлэлтүүдээр бас хэрэгжүүлэх боломжтой гэж харж байгаа учраас ийм санал гаргасан.

Р.Сэддорж: *Нэмэлт тайлбар юм уу? 5 номер, дараа нь 6 номер.*

Б.Лхагвасүрэн: *Соронзонболд гишүүний гаргаж байгаа санал дээр ганцхан л тайлбар байгаа юм. Тэр 75 гээд тоо тавьчихсан байгаа юм. Эрсдэлийн жинг 75. Тэр өөрөө жоохон бас хууль талаасаа бас жоохон зөрчилдөхөөр. Яагаад гэвэл энэ нөгөө энэ тоо юуг чинь Монголбанк Төв банкны тухай хуулиар Мөнгөний бодлогын хороо нөгөө өөрөө шийдвэр гаргаж явдаг учраас шууд Их Хурлаас ингээд өгөх нь 1 дүгээрт асуудал байгаа.*

2 дугаарт эрсдэлийн жин гэдэг бол нөгөө олон улсын БАЗЕЛЬ хорооны стандарт л даа. 100 хувь, тэгээд л дээшээ, доошоо явдаг. Тэгэхээр би зүгээр яах вэ эсэргүүцэж байгаа биш. Зүгээр энэ 75 хувь гэж тоо тавилгүйгээр энэ жигнэх хувийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах ч гэдэг юм уу, тэгээд чиглэлийг нь өгчих. Дараа нь бид нар өөрсдөө энэ дээрээ тэр хуулийнхаа дагуу ажиллаад явчхаж болох юм чинь л гэдэг л тийм л зүйл байгаа.

Р.Сэддорж: *6 номер байхгүй юу? Соронзонболд гишүүн энэ саналыг та өөрөө санал гаргасан хүн.*

Л.Соронзонболд: *Дэмжиж байна. 75 гэж заавал хувь тавихгүйгээр гэвэл эрсдэлээ жигнэх хувийг бууруулах арга хэмжээг авах гэдэг томьёоллоор оруулахад татгалзах зүйл байхгүй.*

Р.Сэддорж: *Дахиж уншъя. Орон нутагт 4.1.орон нутагт олгосон бизнесийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг бууруулах гэж оруулъя. Санал хураалт. 43,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Энэ протоколд тэмдэглүүлье. Миний энэ санал хураах төхөөрөмж ерөөсөө ажиллахгүй байна. Энийг санал дэмжсэнээр оруулаарай саяынх дээр. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах, санал хураалт явж дууслаа.*

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу уншиж танилцуулна. Хэлэлцээд дуусчихлаа шүү дээ.

14.46 цаг

Гурав.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хоёр дахь хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төслийг

байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Гишүүний, энэнээс ажлын хэсгээ танилцуулна биз дээ. Гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 9 дүгээр сарын 27-ны Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, хоёр дахь хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах? санал, дүгнэлтийн төсөл боловсруулах…/үг тасрав/

Р.Сэддорж: *Микрофон нээе Хассуурийн Ганхуяг гишүүний.*

Х.Ганхуяг: *Үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, ажлын хэсгийн гишүүдэд Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Жаргалан, Лувсанжамц, Мөнхсоёл, Цэнгүүн, Энхтуяа, Энхтүвшин, Энхцэцэг гишүүн нар ажилласан байна. Ажлын хэсэг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж, тогтоолын төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн уялдааг хангаж, зөрчлийг арилгаж, тогтоолын төслийн нэр, томьёо найруулгын шинжтэй 39 саналын томьёоллыг бэлтгэлээ.*

Мөн тогтоолын төслийн 2, 3 дугаар хавсралтад албан ёсны статистик тоон мэдээллийн хүртээмжээс хамааран хяналт шинжилгээний зарим үзүүлэлтийг өөрчлөхөөр саналын томьёоллыг бэлтгэсэн болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Мөн ажлын хэсэг хуралдаж байх үед бол олон тооны гишүүдээс бол саналууд зарчмын зөрүүтэй саналууд өргөн баригдсан байдаг. Тэрнээс бол Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд нийцсэн саналуудыг бол санал хураалт явуулж ажлын хэсгийн санал болгож танилцуулж байгаа. Тэгээд та бүхэнд анхаарал тавьсанд баярлалаа. Зарим нэг саналуудыг Байнгын хороогоор хагалуулахаар хойшлуулсан байгаа.

Р.Сэддорж: *Ажлын хэсгийг танилцуулъя. Тогмидын Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны*

дарга, Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн, ХЗДХ-ийн сайд, Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд байна уу? Салдангийн Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, нийгмийн хамгааллын сайд, Жамбын Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн, ХХААХҮ-ийн сайд, Цэндийн Баатархүү Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд байна уу?

Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч ирсэн байна. Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Мягмарсүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны ТНБД, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны ТНБД, Болдын Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал байна уу? Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Бат-Очирын Болд ГХЯ-ны Консулын газрын захирал, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга байна уу, зогсож байгаарай. Чулуунборын Гандирваа БХЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга, алга байна уу? Зоригсайханы Тулга ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга, Хорлоогийн Оюунцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Зияхан Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Баярмагнайн Манлай Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын зөвлөх, Ононгийн Сүлд-Өрлөг Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн хөгжлийн нэгдсэн бодлого,

төлөвлөлтийн газрын зөвлөх гэсэн ийм ажлын хэсэг ирчихсэн байна.

Сайд нар байхгүй байгаа тохиолдолд асуудлыг хойшлуулъя гээд өнгөрсөн хуралдаан дээр ярьсан, гишүүдээс санал гаргаад Байнгын хороог хүндлэхгүй байна гээд. Тэгээд энэ удаа хойшлуулахаар ажлын албанаас бол хүндрэлтэй байдал үүснэ төсөв хэлэлцэхэд гэж байна. Учрал сайд нэг тайлбар хэлэх үү? Учрал сайдын микрофоныг өгье. Учрал сайд.

Н.Учрал: *Ерөнхий сайд тэргүүтэй, 6 сайдын бүрэлдэхүүнтэйгээр нөгөө Шанхай дахь ШХАБ-ын уулзалтад бас оролцож байгаа. Тэргүүн Шадар сайд бас оролцож байгаа. Яг нөгөө сая бас Хятадад айлчлал гээд энэ 14 мега төслийн хүрээнд хэлэлцээрүүд нь цаг нь давхацсан. Тэгээд 1 жилийн төлөвлөгөөг батлахад манай энэ яамнуудын ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ байгаа. Би бол Эдийн засгийн сайдыг төлөөлөөд оролцоод, хариулаад явж болж байна.*

Р.Сэддорж: *Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Ганбаатар гишүүн.*

Ж.Ганбаатар: *Баярлалаа. Энэ биржийн асуудлаа ахиад хөндөхөөс өөр арга алга. Учрал сайд Эдийн засгийн яамыг төлөөлчих бол асуухаас өөр арга алга. Тэгээд энэ бирж чинь болохоор хагас жилээс өмнө бол энэ чинь биржээр нүүрсээ зараад болоод байсан, одоо ингээд уначихсан. Тэгээд сая Монгол Улсын мөнгөний бодлого ярилаа. Тэгээд энэ Боомтын сайдаас би бас асуулт байх юм яг энэтэй уялдаатай л даа. Яагаад нөгөө юу гол боомт маань 24 цаг байж байгаад буцаад 8 цаг болчхов? Энэ чинь таны гол сайн ажил байсан тийм ээ? Өчигдөр, уржигдар сонсогдох нь нүүрсний гаралт дээр бол очер үүсээд эхэлсэн л байна. Тэгээд энэ бирж чинь уучлаарай үнэхээр бирж чинь нүүрсээ зарах сонирхолгүй байна л даа. Тэр 4 компанид зардаг гээд нэг юм яриад байгаа байхгүй юу. Тэр 4 компани чинь биржээр нүүрсээ зарах ёстой шүү дээ.*

Анх тэр Биржийн тухай хууль батлахад тэр 4 компани чинь нэг жилийн хугацаа өгөөч л гээд байсан санагдаж байна. Тэр Ганбат даргаас. Ажлын хэсэг дээр нэг Ганбат нэг тийм юм л яриад л байсан юм. Биржийн хуулиас өмнө батлагдсан, юу гэрээ хийгдсэн 4 компани хүндэтгэн үзэх шалтгаантай гээд л. Тэгээд тэрнээс чинь хойш 2 жил болчихлоо. Наад 4 компани чинь 4-үүлээ биржээр нүүрсээ зарах ёстой, худалдаж авах ёстой. Тэгээд Эрдэнэс Тавантолгой /ЭТТ/ компанийн захирал гээд нэг нөхөр дээр босчоод нөгөө хольж хутгаад нэг юм яриад байна лээ л дээ. Бэлэн мөнгөөр зарж байгаа ч гэсэн. Наранцогт даргаа үгүй ээ наад 4 компаниа биржээр зар, Монгол Улсын хуультай шүү дээ энэ чинь. Зэсээ биржээр зараач дээ тэгээд.

Үгүй тэгээд би нэг их ажил сайн ажлыг чинь цааш нь дэмжээд явъя л даа. Тэгээд биржээр зэсээ зараач, нүүрсээ зараач. Эрдэнэс таван, хэн Энержи ресурс компани гэхэд л 10 сард 10 арилжаа хийсэн байна. Эднийх ингээд бас хувийн компаниуд чинь болоод байгаа байхгүй юу. Энэ биржтэй холбоотой асуудлаараа, тэр нэг ЭТТ компанийн чинь дарга ойлгохгүй юм шиг байна лээ. Тэр чинь ерөөсөө тоо баримтаа мэдэхгүй юм шиг байна лээ шүү дээ. Хагас жил хагас жилээр нь, улирал улирлаар нь тоо баримтаа ойлгохгүй юм байна лээ шүү дээ. Наранцогт даргаа тийм хүмүүст тэгээд уучлаарай, тэгээд тэр 4 компанид нүүрс зарж байна гэж тэр 4 компанид чинь биржээр нүүрсээ зарна гээд тов тодорхой хуультай. Монгол Улсын валютын нөөц түүхэн хэмжээнд нэмэгдсэн нь биржээр нүүрсээ зарсны ач холбогдол шүү дээ. Валютын ханш тогтворжсон. Тэгээд мянган зовлон ярина. Тэгээд Байнгын хороон дээр үг хэлэхлээр араас янз янзын байдлаар сонин…/минут дуусав/

Р.Сэддорж: *Ганхуяг гишүүн нэг минут, Ганбаатар гишүүн нэг минут.*

Ж.Ганбаатар: *Тэгээд бирж гэдэг чинь их тийм сонин ер нь бол аягүй их бэрхшээлтэй л дээ. Хятадын талаас аягүй их юм ярьдаг. Тэгээд наадуул чинь их тийм сонин байдалтай юм сонсогдож байна лээ шүү. Худлаа мухар луу явуулсан, янз янзын байдал үүсгэсэн. Тэгээд аягүй бол тэгээд хууль буруу болсон л юм чихнэ шүү. Тэгээд 1 өдөр наадах чинь аягүй бол дараа жил биржгүй сууж байх магадлал өндөр байна шүү. Тэгээд нүүрсний үнэ унаж байна. Тэгээд энэ боомт ингээд үнэхээр 8 цагаар болж байгаа нь үнэхээр харамсалтай байгаа. Тэр 24 цагаар үргэлжлүүлэх боломж Тулга сайд хариулах л байх л даа, бас л проблемууд бол байгаа болов уу? Тэгэхдээ яг сонсоогүй учраас би бас тодруулж асууя.*

Тэр Уул уурхайн яамнаас тэр агаарын геофизикийн ажил дээр тавигдсан 40 тэрбум төгрөг ахиад үргэлжилсэн үү? Би зүгээр олж харах нь үргэлжилсэн юм шиг байна лээ. Тэр өмнөх ажлын үр дүн ямар байгаа вэ гэдэг асуулт асууя.

Р.Сэддорж: *Учрал сайд.*

Н.Учрал: *Энэ Уул уурхайн биржийн хууль батлагдсанаар бас энэ ил тод болсон, нүүрсний экспорт нэмэгдсэн гээд маш олон давуу талууд үүссэн. Тэгэхээр цаашдаа энэ Биржийнхээ хуулийг хэрэгжүүл гэдэг ийм шаардлагыг барьж байгаа юм. Сая ч гэсэн Хятадад энэ Чайна Энержитэй холбоотой хэлэлцээр хийхэд хүртэл бид нар бол энэ хатуу байр сууриа л барьсан. Биржээрээ явна, биржийнхээ дундаж үнээ барьж явна гэдгээ бол ингээд л хариуцлагатай хэлээд л ингээд шахаж, шаардаад л явж байгаа юм. Одоо бол сүүлд энэ авсан статистикаас харахад бол 10 сард бол биржийн арилжаа нэлээд их идэвхэжссэн. 10 сарын эхний 15 хоногийн байдлаар бол 850 сая тонн нүүрс арилжсан гэдэг ийм мэдээлэл байгаа. Энэ бол 9 сар дахь нийт дүнгээс давсан үзүүлэлт.*

Тэр зэсийн хувьд бол арилжаалагддаггүй хэвээр байгаа. Энэ бол Ганбаатар сайдыг Уул уурхайн сайдаар ажиллаж байх үед 2 удаа зэсийг арилжаалж байсан. Тэрнээс хойш бол ингээд л арилжаагүй юм байна лээ. Тэгээд энэ 4 компани яригдаад байгаа дээр бидэнд энэ ЭТТ компанийнхан ямар мэдээлэл өгч байна вэ гэхээр энэ бол нөгөө тогтвортой гэрээтэй, нөгөө үлдэгдэлтэй 9, 6, 3 сая тонны гээд ийм үлдэгдэлтэй. Тэгээд энэ гэрээг нь цуцлаад явъя гэхээр маш их алдагдал хүлээх, тэгээд энэ гэрээг цуцлах процедур нь маш хүндрэлтэй байгаа учраас энэ нэг тийм тогтвортой гэрээ хийчихсэн. Тэгээд үүнийг энэ чинь бас нэг олон улсын гэрээ учраас буцаагаад энэ гэрээгээ цуцалъя энэ тэр гээд шаардлага тавихаар бол цаад тал нь хүлээж авдаггүй. Тэгээд төлбөр мөнгө нэхэмжлээд байдаг ийм нөхцөлтэй байгаа юм. Тэр 4 компанийн хувьд бол тийм.

Тэгэхээр бусдаар бол Уул уурхайн биржийн хууль хэрэгжээд, ингээд биржээр арилжаалагдаж байгаа, 9 сараас 10 сар бол давсан. Цаашдаа ч гэсэн бид нар энэ Уул уурхайн биржийн хуулиас хэзээ ч буцаж болохгүй. Үнийг ч гэсэн биржийн дундаж үнээрээ тооцно доо л гэдэг ийм шаардлагуудыг л хатуу тавьж байгаа. Тэгээд ер нь цаашдаа ч гэсэн энэ ЗГ-аас энэ Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр бол арга хэмжээ авах тогтоол баталсан. Бид нар 8 хувилбарыг гаргаж тавьчхаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр ил тод, нээлттэй болгох, цаашлаад ЭТТ компанийн менежментийг 8 хэлбэрээр зохион байгуулж болох юм байна гээд олон улсын зөвлөх үйлчилгээ аваад, одоо олон нийтэд танилцуулахад бэлтгэж байна. Ингээд аль болох хамаарлыг холдуулж, бие даасан засаглалтай ийм компани болгоход нь анхаарах ёстой.

Тийм ч учраас цаашдаа бид нар энэ Биржийн хуулиас буцаж болохгүй. Тэгээд энэ хуулиа бариад явна гэсэн ийм байр суурийг бол ЗГ баримталж байгаа. Яг тэр нарийн тоонууд мэдээллүүдийг хэн Наранцогт захирал өгөх үү, хэн Мөнхжаргал.

Р.Сэддорж: *Уул уурхайн яам, ЭТТ хариулаарай. 5 номер дээр суучих, 5 номерыг өгье.*

С.Сүхбат: *Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Сүхбат. Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Агаарын геофизикийн ажил үргэлжилж байгаа, цаашид үргэлжилнэ. Одоогийн байдлаар явц, үр дүн нь бол хэвийн үргэлжлээд явж байгаа.*

Р.Сэддорж: *Хариулт тодорхойгүй байна. Ганбаатар гишүүн 1 минут, 1 минут өгье.*

Ж.Ганбаатар: *Учрал сайдад баярлалаа. Ер нь тэгэхдээ зүгээр нэг зүйлийг хэлэхэд бол Наранцогт захирал та ядаж хагас жил чинь 70 хувьтай байсан шүү дээ биржээр ЭТТ компани. Жижиг Тавантолгой ч ялгаагүй шүү. Тэгээд энийгээ хагас жилээр нэг ядаж сүүлийн хагас жилээрээ 80 болгоорой доо энэ чинь хуультай шүү, 100 хувийн хуультай шүү. Ганбаатар яриад байгаа юм биш шүү дээ.*

Дээрээс нь наадах чинь тэр 4 компани гэж ярьж байгаа Учрал сайдаа. Наад 4 чинь нэгхэн жилийн боломж авсан шүү, Наранцогт захирал мэдэж байгаа. Тэрнээс чинь хойш 2 жил болчихлоо. Бид үнэхээр олон улсын гэрээ гэдгийг нь хүндлээд нэг жилийн дотор бирж рүү шилжих шаардлагыг нь тавьсан. ТӨК-уд байгаа үнэн Хятадын. Тэгээд хууль биелүүлэхгүй гэсэн үг бол биш шүү дээ наадах чинь. Тэгээд 2 жил болчихлоо шүү дээ. Та өөрөө мэдэж байгаа шүү дээ наад компаниуд чинь нэг жилийн дотор бид шилжинэ, биржээрээ нүүрсээ авна гээд…/минут дуусав/

Р.Сэддорж: *Үг хэлсэн. Би эрчим хүчний, Тулга сайд хариулах уу? Тулга сайдын микрофоныг өгье.*

Б.Тулга: *Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Замын-Үүд боомтыг бүтээн байгуулалт боомтын цогцолборын бүтээн байгуулалт энэ онд дууссан. Энэтэй холбоотойгоор өнгөрсөн оны 23 оны 6 сард Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн айлчлалын үеэр Замын-Үүд боомтыг цаашид 24 цагаар ажиллуулах горимын талаар Хятадын боомтын үндэсний хороотой ярилцаж, хэлэлцээд, туршилтын ажлууд явагдаж байгаа. Өнгөрсөн 23 оны 12 сарын 15-наас 30-ны хооронд 14 хоногийн эхний туршилтыг хийсэн. Ингээд 24 оны 4 сарын 1-нээс 9 сарын 30-ны хооронд 6 сарын хугацаатай эд ачааллын үеэр 24 цагаар ажиллуулах энэ туршилтыг амжилттай хэрэгжүүлж дууссан.*

Энэ туршилтын үр дүнгээр эдийн засагт үзүүлж байгаа нөлөө 2 улсын худалдааны эргэлтэд үзүүлж байгаа нөлөө гэж энэ статистик тоонууд эдийн засгийн үзүүлэлтийг 2 талаасаа тооцоод, дараагийн Хятадтай хийх уулзалт дээр энийг ямар горимоор, хэдийд 24 цагаар ажиллуулах вэ, жилийн турш ажиллуулах уу, эд ачааллын үеэр ажиллуулах уу, цаашдаа яах вэ гэдэг энэ шийдвэрүүдийг гаргахаар бид нар ажиллаж байгаа гэдгийг хэлье. Яах вэ хэвлэл мэдээлэл дээр өнөөдөр нөгөө…/минут дуусав/

Р.Сэддорж: *Хариулт, нэмж хариулъя Тулга сайд.*

Б.Тулга: *ААН-үүд дээр бол 9 сарын 30-ны байдлаар дуусна гэдгийг бүрэн тооцоолж яваагүй учраас бөөгнөрөл үүсэж байгаа гэдгийг бид нар ойлгож байгаа. Хятадын талдаа сая Бээжинд бас манай албаны хүмүүс уулзалт хийсэн. Өнөөдөр Эрээн дээр бас*

уулзалт хийж байгаа. Тэгэхээр энэ ажлыг цаашид үргэлжлүүлнэ. Ер нь Хятадын боомтын цагийн хуваарь гэдэг бол 2 талын тохиролцоо дээр явах ёстой. Хятадын талаас 180 орчим хуурай замын авто замын, хуурай замын боомт байгаагаас 1-хэн боомт нь 24 цагийн горимтой. Манайх бол 2 дахь боомт болж орж байгаа. Тийм учраас энэ Хятадын талд боловсон хүчний тоогоо нэмэх, тэр хил гаалийн ажилчдын ажиллах нөхцөлийг хангах гээд нэлээн олон асуудлуудыг бас шийдэх ёстой юм байна лээ. Манайхыг бодвол шийдвэрүүд нь бас харьцангуй удаан, олон шат дамжлагатай гардаг ийм байгаа шүү. Тэгэхээр энэ ажил хэвийн, амжилттай явж байгаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ачаа тээврийн зорчсон тоо 30 хувиар саяын 24 цагийн хугацаанд нэмэгдсэн байгаа. Цаашид төлөв нь нэмэгдэхээр байгаа гэж хариулмаар байна. Баярлалаа танд.

Р.Сэддорж: *Би энэ Хассуурийн Ганхуяг гишүүнээр ахалсан ажлын хэсгийн танилцуулгатай холбоотой асуулт асууя. ЭХЯ-ныхан байгаагүй юм шиг байна лээ. Одоо бол бүсээрээ ярина. Тэгээд энэ говийн бүс нутагт 450мвт-ын станц барина гээд олон жил ярьсан боловч барьж чадаагүй. Тэгээд энэ станцыг чинь хүлээсээр байгаад эрчим хүчний аюулгүй байдлаа ер нь хангаж чадаагүй, Тавантолгойн станцад л найдаад байсан. Тэгээд говийн бүсийн нэг том аймаг Даланзадгадын станц одоо барихгүй бол маш хүндрэлтэй байдалд орж байгаа. Та бүхэн бас мэдэж байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотой 5, 6 сум холбогдсон байгаа. Тэгээд энэ дээр хариулт өгөөч. Энэ станцыг түлхүүр гардуулаад, зурагтай нь түлхүүр гардуулахаар ямар нөхцөлөөр барья гэж та бүхэн шийдэж байгаа вэ? Энэ дээр гарц гаргалгаа яг тодорхой хэлээч. Олон удаа ярьсан, олон удаа асуусан. Тавинбэх дарга 5 номер дээр суучих, 5 номерыг.*

Н.Тавинбэх: *Гишүүний асуултад хариулъя. Би гишүүнийг Даланзадгадын төвд баригдах 50мвт-ын ДЦС-ын талаар асууж байна гэж ойлголоо. Тийм. Таны санаачилгын дагуу ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн хөрөнгөөр 50мвт-ын хүчин чадалтай, нүүрсний технологитой ДЦС баригдахаар оруулсан, орсон байгаа. ТЭЗҮ хийгдчихсэн, ингээд нэгэнт ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон учраас ингээд процесс үргэлжлээд явах учиртай л гэж ингэж ойлгож байна.*

Тавантолгой ДЦС-ын хувьд бол би яам олон удаа мэдээлэл өгсөн байгаа. Тендер маргаантай болсноос болж шүүх дээр гомдол гарч, шүүх, шүүхийн процесс явж байгаа. Анхан шатын болоод давж заалдах шатын шүүхийн шийдвэр гарсан. Дээд шатын шүүхийн, Дээд шүүхэд, дээд тал, дээд шатын шүүхэд гомдол гарсан. Дээд шатын шүүхийн шийдвэрийг хүлээж байна.

Р.Сэддорж: *Би тодруулж асууя. 25 онд тэгээд энэ 50мвт-ын станц дээр юу ч суулгахгүй байгаа юм уу та бүхэн? 5 номер.*

Н.Тавинбэх: *Өнөөдөр нүүрсний технологитой эх үүсвэрийн нэгжийн үнэ 700-аас 2 сая доллар байгаа. Ялангуяа бага чадалтай нүүрсний эх үүсвэрүүдийн нэгжийн үнэ бол үнэтэй байгаа. 50мвт-ын бол бага чадалтайд орно. Тийм учраас ойролцоогоор тооцоход 100 сая орчим долларыг төсөвт үе шаттайгаар суулгаж шийдэх шаардлагатай. Эх үүсвэр шийдэгдчихвэл ямар ч асуудалгүйгээр нүүрсний технологитой эх үүсвэрээр явах боломжтой. Хятад Улсад нүүрсний технологитой эх үүсвэрүүдийн хөрөнгө оруулалтыг хязгаарласантай холбоотойгоор үйлдвэрлэгч нар дээр тоног төхөөрөмж, технологийн хувьд үнэ хямдарч, элбэгшсэн байгаа гэдгийг хэлье. Эх үүсвэрийг л суулгах шийдэх асуудал.*

Р.Сэддорж: *Тэгээд Даланзадгадад ч юм уу, тэр хавьд тог тасраад, янз бүрийн юм болбол тэгээд*

яам тэгээд энэ дээр бас хариуцлагатай хандахгүй бол болохгүй шүү. Олон мянган хүн тэнд байгаа. Тэгээд 50мвт-ын станцыг бол яам бол дэмжихгүй байсаар байгаад л өнөөдрийг бас хүргэсэн юм байна лээ шүү дээ. Цахилгаанаар яах гээд байгаа юм бэ, дулаанаа барь гээд л, тэгж явсаар байгаад л өнөөдрийг хүрсэн юм байна лээ. Тэгээд одоо цахилгаан ч үгүй, дулаан ч үгүй болох вий дээ. Тэгээд энэ дээрээ бас яам хариуцлагатай байхгүй бол, хэлсэн ярьсандаа байхгүй бол, хэдхэн хоногийн өмнө оруулъя гэж ярьсан. Сайдтай ч ярьсан, Сангийн сайдтай ч ярьсан. Төсөл дээр байхгүй байгаад бол харамсаж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дуусламаа.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналууд дээр санал хураалт явуулж эхэлье. Санал дээр л хэлэх байх. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг. Цаашид ажлын хэсэг гээд явчихъя. Санал хураалт. Таны нэр байхгүй байна. Яг өөрийнхөө нөгөө санал гаргасан юун дээр л санал авах юм байна. Санал хураалт. Уншина. Гишүүдээ дуудъя. Техникийн бас асуудал гарч ирж байна. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Техник ерөөсөө болохгүй байна. Илээр хураах уу? Минийх ч болохгүй байна. Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: *Энэ 4 гишүүн Австралийн парламентын зочидтой уулзаж байгаа гэсэн мэдээлэл байгаад байгаа юм. Тэгээд энд ирц дээрээ орчхоод нөгөө талдаа бас адилхан хурал дээр давхар ороод байгаа болохоор энд байхгүйгээр тооцох ёстой юм болов уу гэж бодоод байна л даа.*

Р.Сэддорж: *Горимын санал Лувсанжамц гишүүн.*

Г.Лувсанжамц: *Энэ яг сая хэлснээрээ үндсэн ажилдаа байх ёстой учраас гаднын зочид байна уу, үгүй юу хамаагүй Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаа учраас эндээ гишүүдийг оролцуулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Хэрвээ үгүй бол, одоо байхгүй гэдгээрээ тооцоод авсан нь зүгээр болов уу. Ирцдээ оролцоогүй гэснээр. Дээрээс нь бас саяын саналыг хүчингүйд тооцох дээр дахиж санал хураалт өгмөөр байна. Тийм.*

Р.Сэддорж: *Техник ажиллаагүй гэж үзэж байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгох талаар санал хураалт. Нэмэгдсэн үү, гишүүд нэмэгдсэн үү? Ингээд сая санал, дахиад санал хураахаар чинь дахиад яах юм биш үү? Тэгвэл хүлээх үү? Тэгвэл гишүүдийг хүлээе. Санал хураалт гишүүдийг хүлээе. Алтаншагай гишүүнийг дуудъя, дуудах гишүүдийн нэрийг хэлье. Батсүмбэрэл гишүүн, Соронзонболд гишүүн, Батболд гишүүн, Мөнхсоёл гишүүн, Батнайрамдал гишүүн, Цогтгэрэл гишүүн. Одоо санал хураалт явна одоохон. Горимын саналаар санал хураалт явна. Санал хураалтдаа бэлдээрэй гишүүдээ. Миний энэ төхөөрөмж бол болохгүй байна. Тэгээд бусад гишүүд идэвхтэй оролцоорой.*

Лувсанжамц гишүүний горимын саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураая. Санал 57,1 хувиар дэмжигдлээ. Санал хураалтыг дахин явуулъя. Тогтоолын төслийн 4 дэх заалтыг хасах. Ажлын хэсгээс, санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт 2.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.52 дахь заалтын

“төлөвлөлтийг баталж,” гэсний дараа “идэвхтэй болон идэвх багатай улирлаар ялгаатай бодлого” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтын “бизнесийн орчин,” гэсний дараа “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

6, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын, 5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.16 дахь заалтын “бэрхшээлийг арилгах,” гэсний дараа “хүний нөөцийн тулгамдсан асуудлыг гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлогоор дэмжиж, шаардлагатай” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.3.18, 1.3.19, 1.3.20 дахь заалт нэмэх:

“1.3.18.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх нэг цонхны бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, судалгааны ажлыг зохион байгуулна.

1.3.19.Бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгох, тухайлсан салбаруудын татварын ачааллыг бууруулах бодлогыг боловсруулж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

1.3.20.Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх чиглэлд хариуцлагатай татвар төлөгчийг дэмжиж, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.4.7 дахь заалт нэмэх:

“4.4.7.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг хориглож, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг соёрхон батлуулах арга хэмжээний хэрэгжилт” гэсний “Суурь түвшин”-ний “-” гэснийг “10” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2.1 дэх дэд заалтын “Гоц халдварт өвчний голомт” гэсний “Суурь түвшин”-ний “100” гэснийг “128” гэж, 1.2.3.1 дэх дэд заалтын “бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт төслийг үргэлжлүүлэх” гэснийг “дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3.3 дахь дэд заалтын “төслийг хэрэгжүүлэх” гэсний дараа “/Дарханы арьс ширний цогцолбор болон бусад/” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.3 дахь дэд заалтын "Суурь түвшин"-ний "15" гэснийг "30" гэж, "Зорилтот түвшин"-ний "20" гэснийг "55" гэж, 1.5.2.4 дэх дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "70" гэснийг "60" гэж, 1.5.2.6 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "30" гэснийг "20" гэж, 1.5.2.8 дахь дэд заалтын "Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал"-ын "Бусад эх үүсвэр" гэснийг "Төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж, 1.5.2.12, 1.5.2.13 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "75" гэснийг "35" гэж, 1.5.2.15 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "50" гэснийг "30" гэж, 1.5.2.16 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "50" гэснийг "40" гэж, 1.5.2.18 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "50" гэснийг "30" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2.20 дахь дэд заалтад холбогдох мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ. Араар ажлын хэсгээр чимээгүй байгаарай.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.7.1.4.Эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх үндсэн бичиг баримт болох нэгдсэн сүлжээний дүрэм, түүнтэй холбоотой менежментийн тогтолцоог бий болгох" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Нэгдсэн сүлжээний дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах" гэж, "Хэмжих нэгж"-д "Тоо" гэж, "Зорилтот түвшин"-д "1" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Бусад эх үүсвэр" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Эрчим хүчний яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.1.4 дэх дэд заалтын "Суурь түвшин"-ний "-" гэснийг "69" гэж, 1.8.3.2 дахь дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "100" гэснийг "40" гэж, 1.8.3.4 дэх дэд заалтын "Зорилтот түвшин"-ний "70" гэснийг "30" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.8.3.16, 1.8.3.17 дахь дэд заалтыг нэгтгэн 1.8.3.16 дахь дэд заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"Төсөл, арга хэмжээ"-нд "1.8.3.16.Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6 км авто зам барих," гэж, "Суурь түвшин"-д "50" гэж, "Зорилтот түвшин"-д "100" гэж, "Санхүүжилт"-д "34.927,9" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал"-д "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Зам тээврийн яам" гэж мөр тус бүр харгалзуулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.12.1.1 дэх дэд заалтын "GIS," гэснийг "газар зүйн мэдээллийн систем," гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Миний энэ төхөөрөмж ажиллахгүй байгаа учраас бүх санал дээр дэмжиж оролцсон гэдгийг дундуур нь сануулъя. Протоколд тэмдэглүүлье.

17.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "2.1.1.8.Хорооны хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бий болгох, эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлнэ" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Орон

нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлтийн бэлтгэл ажлыг эхлүүлнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Батсүмбэрэл гишүүн суугаарай. Батсүмбэрэл гишүүн горимын санал гаргах уу, техник ажилласан.

Н.Батсүмбэрэл: *Сая миний техник дээр хоцорч яагаад ажилласангүй. Санал хураалтыг дахиж явуулах саналтай байна.*

Р.Сэддорж: *Хүчингүй болгох тийм ээ? Батсүмбэрэл гишүүний гаргасан горимын саналаар хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг дахиж явуулъя. 17 дахь санал хураалтыг. 57,1 хувиар санал дэмжигдлээ.*

18.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.1.2 дахь заалтын “Төсөл арга хэмжээ”-нд “2.1.2.7.Хөвсгөл аймагт “Хөх баавгайн үүр” төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “30” гэж, “Санхүүжилт”-д “3,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Батшугар гишүүн горимын санал.

Э.Батшугар: *Даргаа сая дэмжсэн. Тэгсэн чинь техникийн алдаа гараад миний санал хүчинтэйд тооцогдсонгүй. Тэгээд горимын санал гаргаж, саяын санал хураалтыг хүчингүй болгоод шинээр санал хураалт явуулна уу гэж хүсэлт байна. Баярлалаа.*

Р.Сэддорж: *Саяын саналыг хүчингүй болгох Батшугар гишүүний гаргасан саналаар санал хураая. Хассуурийн Ганхуяг гишүүн горимын санал гаргая.*

Х.Ганхуяг: *Сая дэмжсэнээр тооцвол болохгүй юу даргаа? Энэ яг техникийн саатал гараад байна, 2 дараалаад техникийн саатал гараад байгаа байхгүй юу.*

Р.Сэддорж: *Энэ техник бол яг нөгөө протокол дээр ингэж яваад байгаа учраас хүчингүй болгох горимын саналаар дахиж хураах юм байна.*

Х.Ганхуяг: *Тэгвэл хүчингүй болгохоор.*

Р.Сэддорж: *Хассуурийн Ганхуяг гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдэж, 18 дугаар санал хүчингүй, санал хураалт хүчингүй болсон. 18 дугаар асуудлыг саналыг дахиж санал хураая. Санал хураалт. 71,4 хувиар санал дэмжигдлээ. Энэ техникийн дэвшил нүүрний царайгаар эд нар байхгүй бол энэ хурууны хээ бол явахгүй юм байна даа.*

19.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1.8 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “720” гэснийг “240” гэж, 2.3.1.10 дахь дэд заалтын “Санхүүжилт”-ийн “200,000.0” гэснийг “165,000.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.1.1 дэх дэд заалтын "Шинээр байгуулах нийгмийн эрүүл мэндийн төв"-д харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2.11 дэх дэд заалтын "Суурь түвшин"-ний "90" гэснийг "0" гэж, 3.1.5.1 дэх дэд заалтын "Зорилтот түвшин"-ний ">150" их буюу тэнцүү гэснийг "100" гэж, 3.2.1.1 дэх дэд заалтын "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандарт шаардлага хангасан цэцэрлэгийн барилга шинээр барих, ашиглалтад оруулах" гэснийг "Стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулах" гэж, мөн дэд заалтын "Ашиглалтад орох цэцэрлэг"-ийн "Суурь түвшин"-ний "34" гэснийг "35" гэж, мөн дэд заалтын "Шинээр баригдах цэцэрлэг" гэснийг "Цэцэрлэгийн шилжих барилга" гэж, "Суурь түвшин"-ний "53" гэснийг "0" гэж, "Зорилтот түвшин"-ний "27" гэснийг "28" гэж, "Санхүүжилт"-ийн "35,616.1" гэснийг "38,189.4" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2 дахь заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "3.1.2.13.Улаанбаатар хотод 2 дугаар шатны эрүүл мэндийн төвийг барих" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "50" гэж, "Санхүүжилт"-д "13,500.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Эрүүл мэндийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.4 дэх дэд заалтын "Ашиглалтад орох сургууль"-ийн Зорилтот түвшин"-ний "25" гэснийг "26" гэж, "Шинээр барих сургууль" гэснийг "Сургуулийн шилжих барилга" гэж, "Суурь түвшин"-ний "53" гэснийг "0" гэж, "Зорилтот түвшин"-ний "36" гэснийг "41" гэж, "Санхүүжилт"-ийн "121,152.8" гэснийг "135,005.7" гэж, мөн заалтын "Шинээр барих дотуур байр" гэснийг "Дотуур байрны шилжих барилга" гэж, "Суурь түвшин"-ний "15" гэснийг "0" гэж, "Санхүүжилт"-ийн "21,734.9" гэснийг "25,414.8" гэж, мөн заалтын "Шинээр барих спорт заал" гэснийг "Спорт заалны шилжих барилга" гэж, "Суурь түвшин"-ний "8" гэснийг "0" гэж, 3.2.1.7 дахь дэд заалтын "Суурь түвшин"-ний "25,000" гэснийг "30.3" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1.9 дэх дэд заалтад харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

25.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.4.1.1 дэх дэд заалтын "Суурь түвшин"-ний "-" гэснийг "23.7" гэж, 3.4.2.1 дэх дэд заалтын "Суурь түвшин"-ний "-" гэснийг "14.2" гэж, 3.5.1.3 дахь дэд заалтын "Арга хэмжээний хэрэгжилт" гэснийг "Мян.хүн" гэж, "Суурь түвшин"-ний "-" гэснийг "1.09" гэж, "Зорилтот түвшин"-ний "100" гэснийг "2.5" гэж, 3.5.1.4 дэх дэд заалтын "Арга хэмжээний хэрэгжилт" гэснийг "Мян.хүн" гэж, "Суурь түвшин"-ний "-" гэснийг "1.43" гэж, Зорилтот түвшин"-ний "100" гэснийг "2.0 гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

26.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.5.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "3.5.1.5.Жижиг, дунд,

бичил бизнес эрхлэгчдийн дэмжих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Санхүүжилт”-д “8,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1 дэх заалтын “Зэвсэгт хүчний” гэсний дараа “үүрэг” гэж нэмж, 4.6.1.7 дахь дэд заалтын “Зорилтот түвшин”-ний “3” “гэснийг “2” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

28.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-ын “Шууд хөрөнгө оруулалт” гэснийг “Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

29.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Тэргүүлэх чиглэлийн үр дүн”-ийн 3 дахь заалтын “Үндэсний статистикийн хороо” гэснийг “Нэгдсэн Үндэстний Байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

30.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-гийн 1.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “2.8” гэснийг “3.5” гэж, 1.9 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 2.2 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “11-13” гэснийг “12” гэж тус тус өөрчилж, 1.10 дахь заалтад харгалзах мөр тус бүрийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

31.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.1 дэх заалтын “Зүрх судасны өвчин, хорт хавдрын өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/”-нд харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “10,000 хүн амд ногдох халдварт өвчний тоо” гэснийг “Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин /30-70 нас/” гэж, “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “973.9” гэснийг “41.8” гэж, “Зорилтот түвшин” “779.1” гэснийг “41.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

32.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж”, “Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж /Монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/”, “Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж” гэсэн шалгуур үзүүлэлтийн “Мэдээлэл цуглуулах давтамж”-д харгалзах мөр тус бүрийн “Жилд нэг удаа” гэснийг “Гурван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

33.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 3.2 дахь заалтын “Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж”-д харгалзах мөр тус бүрийг хасаж, мөн заалтын “Тухайн жилд бүрэн дунд боловсрол

эзэмшсэн 18 настай хүн ам”-ын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “77.1” гэснийг “81” гэж, “Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “60” гэснийг “48.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “66” гэснийг “50” гэж, “Сургалтын орчны стандарт хангасан сургуулийн хувь”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “71” гэснийг “50.5” гэж, “Хүрэх түвшин”-ний “76” гэснийг “52” гэж, 3.3 дахь заалтын “Хүүхдийн эрхийн индекс”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, 3.8 дахь заалтын “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,1 хувиар санал дэмжигдлээ.

34.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн”-ийн 4.2 дахь заалтын “Суурь он”-ны “2017” гэснийг “2019” гэж, “Суурь түвшин”-ний “63.1” гэснийг “64.8” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ.

35.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”- ийн 1.1.2 дахь заалтын “хөрөнгийн өгөөж /ROA/” гэсний дараа “, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж нэмж, “Зорилтот түвшин”-ний “4” гэснийг “77” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ. 35.Тогтоолын төслийн.

36.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 1.1.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, Суурь түвшин”-ний “2.5” гэснийг “3.5” гэж, 1.4.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” “гэж, “Суурь түвшин”-ны “50” гэснийг “229” гэж, “Хүрэх түвшин”-ний “100” гэснийг “200” гэж, 1.7.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “20” гэснийг “40” гэж, 1.8.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “-” гэснийг “2” гэж, мөн заалтын “Мэдээллийн эх сурвалж”-ийн “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэснийг “Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж, 1.9.1 дэх заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний ”13“ гэснийг “17.8” гэж, 1.10.1 дэх заалтын “Эргүүлэн болон дахин ашигласан усны хэмжээ”-ний “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ны “10” гэснийг “17” гэж, “Зорилтот түвшин”-ний “15” гэснийг “19” гэж, “Дахин хог хаягдлын эзлэх хувь”-ийн “Суурь он”-ны “2021” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “15.7” гэснийг “21.1” гэж, “Зорилтот түвшин”-ний “19” гэснийг “27” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78,6 хувиар санал дэмжигдлээ.

37.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”- ийн 1.11.2 дахь заалтын “Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно” гэснийг “Ашиглалтад өртөмтгий ургамлын ашиглалтын нөөцийг тогтоож, амьтны ашиглалтын нөөцийг нэмэгдүүлнэ” гэж, “Ургамлын зүйл”-ийн “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “7702” гэснийг “5” гэж, “Зорилтот түвшин”-ний “7702” гэснийг “2” гэж, мөн заалтын “Амьтны зүйл” гэснийг “Сэргээн болгон сэлгэн нутагшуулсан амьтны зүйл” гэж, “Суурь он”-ны “2020” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “756” гэснийг “7”, “Зорилтот түвшин”-ний “756” гэснийг “7” гэж, 1.11.3 дахь заалтын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Зорилтот түвшин”-ний “10” гэснийг “5” гэж, 1.11.4 дэх заалтын

“Мэдээллийн цуглуулах давтамж”-ийн “Жилд нэг удаа” гэснийг “Таван жилд нэг удаа” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78,6 хувиар санал дэмжигдлээ. Протоколд тэмдэглэж байгаа биз. Энэ санал өөрийн биеэр ирээд өгч чадахгүй техникийн шалтгаанаас өгч чадахгүй байгаа гишүүдийн.

38.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын “Хөтөлбөрийн үр дүн”-ийн 4.2.1 дэх заалтын “Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдол”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “21” гэснийг “20” гэж, мөн заалтын “Давтан шинжилгээ”-ний “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “549” гэснийг “916” гэж, “Зорилтот түвшин”-ний “440” гэснийг “800” гэж, 4.3.1 дэх заалтын “Зорилтот түвшин”-ний “76.5” гэснийг “78.4” гэж, 4.6.2 дахь заалтын “Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газар”-ын “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “8” гэснийг “12”, “Зорилтот түвшин”-ний “6” гэснийг “10” гэж, мөн заалтын “Усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэг”-ийн “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж, “Суурь түвшин”-ний “5” гэснийг “6” гэж, мөн заалтын “Хөрсний чанарын стандартаас давсан бохирдолтой цэгийн тоо”-ны “Суурь он”-ны “2022” гэснийг “2023” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78,6 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн бүтэц, нэр томьёо, найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх эрхийг олгох санал хураалт тийм ээ. Санал хураалт. Санал хураалт дуусаагүй шүү. 78,6 хувиар санал дэмжигдлээ.

Одоо гишүүдийн гаргасан саналаар санал хураалт үргэлжилнэ. 1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.9.бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу. Тайлбарлах уу? Санал хураалт. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.2 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.2.2.Орон нутагт иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх суурьшлын бүсийн инженерийн дэд бүтцийг шинээр болон шинэчлэх төслийг хэрэгжүүлэх /Төв, Сэлэнгэ/” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Арга хэмжээний хэрэгжилт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “10,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. Санал хураалт. 28,6 хувиар санал дэмжигдсэнгүй. Гишүүд санал хураалтад оролцсон биз дээ, оролцож байгаа биз дээ?

3.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.2.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.2.3.7.Дархан-Уул аймагт малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах болон дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн цогцолбор байгуулах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Дэд бүтцийн бүтээн байгуулалт” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Санхүүжилт”-д “100,000.0” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж

тус тус нэмэх. Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр. Санал хураалт. 21,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.3.1.6.Хөдөө, аж ахуйн /газар тариалан/ гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, боловсруулалтын түвшинг ахиулах төслийг орон нутагт хэрэгжүүлэх /Төв, Дархан, Сэлэнгэ/" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Арга хэмжээний хэрэгжилт" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "100" гэж, "Санхүүжилт"-д "9,000.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. Санал хураалт. Соронзонболд гишүүн одоо таны юу байгаа юм байна шүү дээ. 14,3 хувиар санал дэмжигдсэнгүй. Би бол дандаа дэмжээд байгаа шүү. Протоколд тэмдэглүүлье.

5.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.3.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.3.1.7.Дунд хоршооны хөгжлийг дэмжих газар тариалангийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, хадгалах зоорь байгуулах" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Арга хэмжээний хэрэгжилт" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "100" гэж, "Санхүүжилт"-д "5,000.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. 14,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

6.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.4.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.4.1.3.Уул уурхайн хайгуул, ашиглалт, олборлолт, сонгон шалгаруулалтын программ, техник хангамжийг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Арга хэмжээний хэрэгжилт" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "80" гэж, "Санхүүжилт"-д "15,000.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. Санал хураалт. 14,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Протоколд дэмжсэнээр санал оруулж байгаа.

7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.1 дэх заалтын "Бодлогын үндэслэл"-д "МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.2" гэж, "Төсөл, арга хэмжээ"-нд "1.5.1.7.Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "30" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Зам, тээврийн яам" гэж, мөн заалтын "Бодлогын үндэслэл"-д " МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.3.2.4" гэж, "Төсөл, арга хэмжээ"-нд "1.5.1.8.Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг ашиглалтад оруулж байнгын ажиллагааатай боомт болгох" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "100" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Зам, тээврийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт. Энхцэцэг гишүүн. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Энхцэцэг гишүүн горимын саналтай юу? Дэмжигдсэн байна. Дэмжиж санал өгсөн үү?

М.Энхцэцэг: *Дэмжсэнээр.*

Р.Сэддорж: *Дэмжсэнээр. Та бид хоёр адилхан байна. Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье Энхцэцэг гишүүн. Энэ санал дэмжигдсэн.*

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.5.2.21.Мандал сумаас Түнхэл тосгон хүртэлх 35 км хатуу хучилттай замын төслийг хэрэгжүүлэх" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "50" гэж, "Санхүүжилт"-д "16,250.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Зам, тээврийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. Санал хураалт. 28,6 хувиар санал дэмжигдсэнгүй. Орон нутагт чинь ямар мөнгө байх вэ дээ, энийг хийх Төв аймагт тийм мөнгө байх уу? Санал дэмжигдсэнгүй.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.5.2 дахь заалтын "Төсөл арга хэмжээ"-нд "1.5.2.22.Улаан-Уул, Баянзүрх, Ринчинлхүмбэ, Цагааннуур сумдыг холбосон гүүрэн байгууламжийг шинэчлэх" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"-д "Хувь" гэж, "Зорилтот түвшин"-д "50" гэж, "Санхүүжилт"-д "10,000.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Зам, тээврийн яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. Санал хураалт. 14,3 хувиар санал дэмжигдсэнгүй. Би дэмжиж санал өгсөн.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.7.1.5.Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Нам хүчдэлийн стандартыг шинэчлэн боловсруулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах" гэж, "Хэмжих нэгж"-д "Тоо" гэж, "Суурь түвшин"-д "0", "Зорилтот түвшин"-д "1" гэж, "Санхүүжилт"-д "600.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал тайлбарлах уу та? Шаардлагагүй гэж байна. Энхцэцэг гишүүний оруулсан саналыг, саналаар санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ. Баяр хүргэе гэж болдог юм уу, болохгүй юу, арай болоогүй юм байна. Болоогүй юм байна.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.7.3.16.Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын Нар, 5 МВт, 20 МВт-цаг-ын Батарейн станц барих" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих нэгж"- д "Хувь" гэж, "Суурь түвшин"-д "0", "Зорилтот түвшин"-д "100" гэж, "Санхүүжилт"-д "99,820.0" гэж,"Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Эрчим хүчний яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Энхцэцэг гишүүн саналаа тайлбарлана. Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: *Энэ дээр төр, хувийн хэвшил гэдэг юун дээр нэг техникийн алдаа гарсан байна. Энийг улсын төсөв гэсэн байдлаар өөрчлүүлье гэж.*

Р.Сэддорж: *Техникийн алдааны улмаас төр, хувийн хэвшлийн түншлэл гэснийг улсын төсөв гэж оруулах юм байна тийм үү? Санхүүжих дүн 99 тэрбум 820 сая зөв үү? Энэ санал дээр Мөнхсоёл гишүүн яах юм уу, үгүй биз дээ? Зөвхөн санал гаргасан гишүүн л үг хэлэх*

юм байна. Өөр байхгүй юм байна. Үг байхгүй. Тэндээс тайлбар авах юм уу, тийм тайлбар авахгүй юм байна. Шууд санал хураалт явах юм байна. Ингээд 11 дүгээр санал, 11 дүгээр санал хураалт Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан санал дээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 28,6 хувиар санал дэмжигдсэнгүй. Энхцэцэг гишүүн горимын санал гаргая.

М.Энхцэцэг: *Энэ дээр тайлбар хийж болох уу? Тэгээд мөн ЭХЯ-наас тайлбар авъя гэж бодож байна. Та бүхэн өчигдөр би бас нөгөө ажлын хэсэг дээр тайлбарласан л даа. Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгууд болохоор 110 киловольтын нэг хэлхээтэй, насжилт өндөртэй маш урт шугамаар тэжээгддэг. Сая зун энэ аймгуудаар саяхан явахад засвар орж байгаа гээд цахилгаангүй сууж байгаа байхгүй юу. Өнөөдөр 2024 он цахилгаангүй аймгууд, сумууд сууж байгаа байхгүй юу. Тэгээд өнгөрсөн онуудад гээд тэгэхэд чинь Хархорины шугам дээр 2 удаа тулгуур унасан, хэдэн 7 хоногоор бүхэл бүтэн 3 аймаг, хэдэн 10 сумууд цахилгаангүй сууж байгаа. Өвлийн тэсгим хүйтэнд энэ тулгуур унана. Маш их насжилт өндөртэй, тэгээд 1 хэлхээтэй.*

Тэгэхээр улсынхаа төсвөөр энэ бага хөрөнгө оруулалттай нар, салхины зургаахан сарын дотор барьчихна энэ эх үүсвэрүүдийг. Тэгэхээр ийм төслүүдийг хэрэгжүүлж, энэ аймгуудын цахилгаан хангамжийг найдваржуулж, энэ олон аймгийг, сумыг хөлдөхөөс авраач л гэж байгаа юм.

Р.Сэддорж: *Дэгд бол тайлбар авна гэсэн юм байхгүй л болчхоод байна л даа. Техникийн саатал янз бүрийн юм гарсан уу сая? Та яасан дэмжсэнээр орсон уу? Би нэмэгдээд юу болж байна, би чинь нэмнэ шүү дээ. Энэ дэгийн тухай дэгээр бол чуулган дээр л нэг боломж байгаа юм байна. Байнгын хорооны дэмжээгүй саналууд чуулганаар орж санал хураалт болох юм байна. Түүн дээр л та дэлгэрэнгүй саналаа хэлж, ЭХЯ бол дэмжиж байгаа юм байна тийм үү? ЭХЯ нийт гишүүддээ хэлээд сайд Чойжилсүрэн сайд хэлээд ингээд болчих байлгүй дээ тийм ээ. Сая тэгээд яачхав? Энэ чинь хамгийн чухал л юмнууд байгаа юм л даа. Цахилгаангүй бол тэгээд явахгүй л дээ. Батнайрамдал гишүүн, горимын санал Батнайрамдал гишүүн.*

О.Батнайрамдал: *Сая төхөөрөмж дээр асуудал гарчих шиг боллоо. Тэгээд сая явуулсан саналыг хүчингүй болгоод, дахиж нэмэлт нэмж санал хурааж өгнө үү гэж горимын санал гаргаж байна. Баярлалаа.*

Р.Сэддорж: *Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Санал хураалт 57,1 хувиар дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо. 11 дэх саналыг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан 11 дэх саналыг дахин санал хураалт. Санал хураалт. Батчимэг гишүүн горимын санал гаргах уу? Батчимэг гишүүн горимын санал. Микрофон өгье.*

П.Батчимэг: *Саналаа өгөх гээд харин энэ юу ажилласангүй. Тэгээд дахиад санал хураалгая. Саяын саналыг хүчингүй болгох, дахин санал.*

Р.Сэддорж: *Батчимэг гишүүний горимын санал орж байна. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 64,3 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй болсон. Ингээд 11 дэх санал хураалтыг дахин санал хураая. Санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.*

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "1.7.3.17.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж, "Хэмжих

нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0”, “Зорилтот түвшин”-д “100” гэж, “Санхүүжилт”-д “121,600.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. Одоо энэ чинь заавал ингээд техникт захирагдах ёстой юм уу ер нь. Хүн өөрийн биеэр ирээд санал өгч байхад чинь. Горимын санал гаргая. Миний бие горимын санал гаргаж байна. Санал хураалтыг дахин явуулах санал гаргаж байна. Санал хураалт явуулъя. Хүчингүй болгох. 71,4 хувиар санал хураалт хүчингүй болж байна. Санал дэмжигдэж байна.

12 дахь санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. Техникээс асууж байна. Түр та бүхэн байж байгаарай. Батчимэг гишүүн горимын санал гаргах уу? Саяын санал хураалт дээр. Би нэг горимын санал гаргая. Яам дэмжиж байгаа асуудал байгаа биз дээ, яам, ер нь тийм ээ зүгээр асуухад. Ингээд 12 дахь санал техникийн саатлын улмаас санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Санал хураалт. 53,8 хувиар санал дэмжигдэж, санал хураалт хүчингүй боллоо. 12 дахь санал хураалт, дахин санал хураалт. Санал хураалт. 30,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 1.7.3 дахь заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “1.7.3.16.Даланзадгадад 50МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц байлгүй дээ, дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Төслийн бэлтгэл ажлын явц” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Зорилтот түвшин”-д “20” гэж, “Санхүүжилт”-д “405,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрчим хүчний яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж.

Энэ мөнгөн дүнг нь би тайлбарлах юм байна. Тэгээд мөнгөн дүнгийн 20 хувийг нь л тавиулах энэ 450-хаа тийм ээ, 20 хувийг нь л тавиулах. Өөрөөр хэлбэл 81 тэрбум бол тавихаар ингэж орж байгаа юм. Энэ төслийг эхлүүлэхгүй бол хүндрэлтэй байдал үүсэж байгаа. Тэгээд та бүхэн бас нэг их яриулалгүйгээр мэдэж байгаа байх гэж бодож байна. Тавинбэх дарга ч гэсэн ярьсан, ТЭЗҮ хийгдчихсэн байгаа. Тэгээд Дорнодынх шиг, Сэлэнгэ шиг ингээд бариад дуусгах л ийм л ажил байгаа. Санал хураалт. 38,8, 38,5 хувиар санал дэмжигдсэнгүй.

14.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 2.3.1 дэх заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.23.Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг барилга байгууламжийн норм, норматив сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, мөн заалтын “Төсөл, арга хэмжээ”-нд “2.3.1.24.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалгын ажлыг оршин суугчдын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийнэ” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр”-т “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Тайлбар Лувсанжамц гишүүн.

***Г.Лувсанжамц:** Сайн байцгаана уу. Энэ нөгөө ажлын хэсэг дээр оруулаад найруулгыг нь жоохон засаад ир гэсэн зүйл байсан юм. 2.3.1.23 болохоор одоо*

байгаа барилгын ажил, зураг төслийн ажлын норм норматив нь шинэчлэгдэхгүй жоохон удчихаад байгаа юм, тэрнийг нь хурдлуулъя гэдэг энэ Барилгын хөгжлийн төвд нь барилгын норм нормативын санхүүжилтийн хүрээнд нь хийгээд өгөөч гэсэн тийм ажил байгаа. Яамныхан бас өөрсдөө дэмжиж байгаа.

2.3.1.24 болохоор нөгөө нийслэлд байгаа нөгөө угсармал орон сууцууд нийтдээ 500 орчим блок барилга байгаа. 60, 70 мянга орчим өрх оршин суудаг. Энийг нь Орон нутгийн хөгжлийн сан мөн оршин суугчдынх нь оролцоотойгоор энд хамтраад нэгдсэн журмаар дулаалгын ажлыг хийе гэж байгаа юм. Энэ дулаалгын ажлыг хийх юм нийслэлийн дулааны хангамжийн 18 хувийг хэмнэх боломжтой буюу дахиж шинээр 18 хувийн орон сууц нэмэгдэх боломжтой ийм сул орон зай гаргах чухал ажил байгаа юм шүү. Дэмжиж өгөхийг хүсэж байна. Хот даяараа 500 орчим блок хот даяар.

Нийтдээ нийслэл дээр 50 орчим тэрбум төгрөг Орон нутгийн хөгжлийн сан дээр байгаа. 1 барилгыг дулаалахад ойролцоогоор 600 сая төгрөг гэж байгаа. Энийг нь хэдэн хувийг нь иргэд, оршин суугчид гаргах юм бэ гэдгийг нь бэлтгэл ажлыг нь хийлгэе гэж байгаа юм. Шууд юуг нь хийхгүйгээр. Иргэдтэй нь эхлээд ярилцах ёстой, оршин суугчид нь хэдэн хувийг нь гаргах боломжтой гээд тийм байдлаар явах ёстой болов уу гэж бодож байна. СӨХ-н төлбөр ч юм уу тийм ээ, тийм зүйлүүдээс нь оролцуулаад хамтдаа дулаалаад, нэгдсэн журмаар дулаалаад явъя гэсэн тийм ажил байгаа. Энэ бэлтгэл ажлыг нь л хийнэ гэдэг дээр нь хийж байгаа. Тийм, бэлтгэл ажлыг нь л хийлгэх гээд байгаа юм. Санал асуулгыг нь аваад хийх юм уу, хийхгүй юм уу гээд, боломжтой юм уу, боломжгүй юм уу гэдэг тийм бэлтгэл ажлыг гэсэн томьёолол байгаа юм шүү.

Р.Сэддорж: *Санал хураалт, 14 дүгээр санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийн.*

15.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 3.2.1 дэх заалтын "Төсөл, арга хэмжээ"-нд "3.2.1.11.Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэж, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах" гэж, "Шалгуур үзүүлэлт"-д "Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн, сургалтын байгууллагын тоо" гэж, "Хэмжих нэгж"-д "Тоо" гэж, "Суурь түвшин"-нд "10" гэж, "Зорилтот түвшин"-д "20" гэж, "Санхүүжилт"-д "500.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Боловсролын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам" гэж, мөн дэд заалтын "Шалгуур үзүүлэлт"-д "Пассив барилгын шаардлагад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий сургууль, цэцэрлэгийн нэг маягийн барилгын зураг төсөв" гэж, "Хэмжих нэгж"-д "Тоо" гэж, "Суурь түвшин"-нд "0" гэж, "Зорилтот түвшин"-д "5" гэж, "Санхүүжилт"-д "400.0" гэж, "Санхүүжилтийн эх үүсвэр"-т "Улсын төсөв" гэж, "Үндсэн хариуцагч"-д "Боловсролын яам" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Тайлбар Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: *Энэ бас өчигдөр ажлын хэсгийн хурал дээр дэмжигдсэн санал. Тэгэхдээ нөгөө зорилтот түвшин, суурь түвшин гэдэг тоонуудыг нь тодорхой болгоод ирээч гээд Боловсролын яам, Хот байгуулалтын яамтай ярилцаад тодруулаад ирсэн зүйл байгаа юм шүү. Энэ ямар ажил хийх гээд байгаа юм бэ гэхээр манайх орон нутгийн сургуулиуд, цэцэрлэгүүд ялангуяа сумын төвд байдаг сургууль, цэцэрлэгүүдийн халаалтын зардал нь буюу урсгал зардал*

дээрээ урсгал зардлын нийт хэмжээ дотор эзлэх халаалтын зардал нь 80 хувь болчхоод байгаа юм. Тэгэхээр нөгөө төсвийн мөнгийг зүгээр нүүрс болгоод шатаагаад байгаа л гэсэн тийм нөхцөл байдалтай байгаа. Энийг хэдүүлээ ЗГ-ын нөгөө 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр оруулсан байгаа. Сургуулиуддаа ер нь эхлээд эрчим хүчний аудитыг нь хийчихье, үнэлгээг нь хийлгэчихье. Тэгээд нэг маягийн цэцэрлэг байгаа, нэг сар, нэг маягийн сургуулийн барилгууд байгаа. Тэрэнд нь таарснаар хэрвээ пассив технологи болох эрчим хүчний хэмнэлттэй болгох боломжтой тийм нэг маягийн зураг төсвийг нь хийлгэе гэж байгаа юм.

Энэ дээр зорилтод түвшинд 5 гэж орсон байгаа нь болохоор 2 нь цэцэрлэгийн барилга юм, 2 нь сургуулийн барилга, 1 нь болохоороо МСҮТ юм. Тэгэхээр нийтдээ ингээд цаашдаа ингээд үнэлгээгээ хийж аваад, эрчим хүчний үнэлгээгээ хийгээд, тэгээд боломжтой байх юм бол энэ нэг маягийн барилгын зураг төсвөөрөө хийнэ гэж байгаа юм. Үнэлгээг нийтдээ 500 сая төгрөг, нэг маягийн зураг төслийг 5 төрлийнхийг 400 сая төгрөг буюу 1 барилгыг 80 сая төгрөгөөр зураг төслийг нь зурна гэж байгаа юм. Энийг хэрвээ энэ жилдээ 25 ондоо багтаагаад хийчих юм 26, 27 ондоо үнэлгээ хийсэн барилгуудаа сургуулиудаасаа эхлээд дулаалаад эхлэхлээр урсгал зардлынх нь 80 хувь нь хэмнэгдээд, тэр хэмжээгээрээ багш нарын цалинг нэмэх ч байдаг юм уу, сургалтын чанарыг сайжруулах тийм орон зай үүсэх ийм чухал ажил байгаа гэж бодож байгаа болохоор дэмжиж өгөхийг хүсэж байна.

Р.Сэддорж: *Санал хураалт. 38,5 хувиар санал дэмжигдсэнгүй. 16.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.1.2.14 дэх дэд заалтын "хяналтыг боловсронгуй болгох" гэснийг "хяналтыг боловсронгуй болгож, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгох тогтолцоог бий болгох" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Тайлбар.*

Г.Лувсанжамц: *Энэ найруулгыг нь л зассан юм. Энэ хяналтыг боловсронгуй болгоно гээд дуусчихсан байсан өгүүлбэр дээр нь араас нь нэмж өгч байгаа юм. Хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл олгоно гэсэн ийм тогтолцоог бий болгоно гэж байгаа юм. Нөгөө яг найруулга нь зөв байхгүй бол яг хийх ажил нь ондоо болчих гээд. Хэрвээ энэ чигээрээ явах юм яг өнөөдрийг хүртэл бидэнд тулгамдаад байгаа газрын төлөвлөгөө нь тусдаа, хот байгуулалтын төлөвлөгөө нь тусдаа гэдэг зүйл нь засагдахгүй учраас энэ тогтолцоогоо сайжруулахдаа ер нь энэ төлөвлөгөөнүүд хоорондоо уялдаж байя. Хотынхоо төлөвлөлтийгөө дагаад газрын зөвшөөрлөө олгоё гэсэн ийм тодорхойлж өгч байгаа найруулгын өөрчлөлт байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсэж байна.*

Р.Сэддорж: *16 дугаар санал хураалт. Санал хураалт. 46,2 хувиар санал дэмжигдсэнгүй.*

17.Тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 1.8 дахь хэсгийн "Шалгуур үзүүлэлт"-ийн "Хүлээн авах" гэсний дараа "Идэвхтэй улиралд хүлээн авах" гэж нэмж, мөн хэсгийн "Суурь түвшин"-ний "0.6" гэснийг "0.38" гэж, "Зорилтот түвшин"-ний "1.5" гэснийг "0.9" гэж тус тус өөрчилж, мөн хэсгийн "Шалгуур үзүүлэлт"-д "Идэвх сул улиралд хүлээн авах гадаад жуулчид" гэж, "Суурь түвшин"-нд "0.22" гэж, "Зорилтот түвшин"-д "0.6" гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найдалаа гишүүний энэ 2 санал байгаа юм байна. Тэгээд ажлын хэсэг дээр бол агуулга юм нь бол яачихсан

орчихсон, давхардаж байгаа юм шиг байна. Та саналаа тайлбарлах уу? Найдалаа гишүүн микрофон, микрофон дээр хэлчих.

Б.Найдалаа: *Миний гарсан санал давхацсан. Дээр нь дэмжигдсэн талаас татан авч байна.*

Р.Сэддорж: *Найдалаа гишүүний саналыг татаж авсанд тооцлоо. Санал хураалтгүйгээр. Төсөлтэй холбоотой тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дуусла. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дуусла. Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг уншиж танилцуулна. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин Байнгын хороонд үг хэлнэ. Тэмүүжин гишүүний.*

Х.Тэмүүжин: *Саяын баталж байгаа тогтоолын төсөлтэй холбоотой үг байгаа юм. Сая батлагдаж байгаа тогтоолын төсөл дотор ХЗБХ-ны эрхлэх асуудалтай холбоотой нэг бүтэн сэдэв явж байна. Тэр сэдэв дотор ямар алдаа гарсан бэ гэхээр өнгөрсөн бид нарын ээлжит бус чуулганаар ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрийг баталсан. Тэр үед ХЗБХ болон чуулган дээр батлагдаж дэмжигдсэн концепцоос өөр санал ороод ирчихсэн байгаа байхгүй юу.*

Тэгээд энэ концепцоос өөр санал яагаад ороод ирэв гэсэн чинь Хууль зүйн яамнаас бид асуулаа. Хууль зүйн яам манайд ийм санал өгөөгүй, манай санал биш гэж хэлж байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуулаа. Эдийн засгийн хөгжлийн яам хуучин төсөл дээрээс шилжүүлж тавьж байхдаа техникийн алдаа хийсэн байна гэж хэлж байна. Тэгэхээр энэ заалтыг хасах ямар боломжтой байна гэдэг асуудал хөндөгдөж байна. Уг нь ХЗБХ хуралдсан бол энэ дээр угаасаа яригдах байсан. Гэтэл ХЗБХ-оор ороогүй, зөвхөн Эдийн засгийн байнгын хороогоор орж байгаа. Тэгээд энэ заалт дотор хуулийн нэг байгууллага байгуулах тухай бүтэн заалт явж байгаа байхгүй юу.

Би хэлээд өгье. Тэгэхээр Хууль зүйн яамыг төлөөлж явж байгаа хүний микрофон дээр үгийг авах хэрэгтэй байна. Эдийн засгийн хөгжлийн яамыг төлөөлж явж байгаа хүний микрофон дээрх үгийг авах хэрэгтэй байна. Хавсралтын 4.3.8, тийм хавсралт 1-ийн 4.3.8. Өмнөх хэлэлцүүлэг болон өмнөх шийдвэр дээр яасан бэ гэхээр бид бол ЗГ-т үүрэг чиглэл өгөөд, ЗГ өөрөө хийх ажлынхаа хүрээнд гэрч, хохирогчийг хамгаалах болон шүүхийн аюулгүй байдлыг хангах шинэ алба байгуулна. Энэ алба нь эрүү шүүлттэй холбоотой болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй байна гэдэг тийм батлагдсан.

Гэтэл одоо энэ хавсралтад тэс өөр энэтэй эрх мэдэл булаацалдахуйц дахиад нэг чиг үүрэг бүхий байгууллага байгуулахаар ороод ирчихсэн байгаа. Энэ бол Хууль зүйн яамны одоо боловсруулж байгаа хууль ерөөсөө биш, барьж байгаа концепц нь биш. Хууль зүйн яам энэ дээрээ бас нэг тайлбар хэлэх ёстой байх нэг. Эдийн засгийн хөгжлийн яам хууль зүйн асуудлыг мэдэж шийдэж орж ирэх эрхгүй этгээд. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яамыг төлөөлж байгаа хүн бас энэ дээр нэг тайлбар хэлэх ёстой байх. ХЗБХ-ны дарга бол юу гэж хэлсэн бэ гэхээр энэ 2 байгууллага албан бичгээр ХЗБХ руу энэ асуудлаараа бичиг өг гэж хэлсэн. Хууль зүйн яам энэ бол манай санал биш гэдгээ албан бичгээр өг, Эдийн засгийн хөгжлийн яам энэ нь техникийн алдаа байна гэдгээ албан бичгээр өг гэж хэлсэн. Тийм учраас тэр албан бичгүүдээ бас бичээд маргааш гэхэд ХЗБХ руу ирүүлмээр байна. Энэтэй холбоотойгоор

ХЗБХ яаж хуралдах вэ гэдэг асуудлаа бас тэндээ шийдэх хэрэгцээ байна.

Р.Сэддорж: *Болчихсон уу? Тэгээд одоо ХЗБХ-г дахиж хуралдуулах юм уу? Тэмүүжин гишүүн одоо та гарц гаргалгаагаа яагаад, Даргын дэргэдэх зөвлөл рүү ярих хэрэгтэй байх. Лодойсамбуу гишүүн санал байна уу? Тэмүүжин гишүүн тэгвэл маргааш чуулганы хуралдаан дээр хэлэх боломж байгаа юм байна. Тийм. Тэгээд түүн дээрээс яаж цаашаа өрнөхийг бол тэгээд яг тэндээс цаашаа явах юм байна. Тэгэхээр та чуулганы нэгдсэн хуралдаан дээр л хэлэх хэрэгтэй юм байна. Болчихсон уу? Тэмүүжин гишүүн үгээ дуусгачих.*

Х.Тэмүүжин: *Мэдээж хэрэг энэ бол зүгээр алдааны хувьд бол энэ бол ЗГ-ын өөрийнх нь алдаа. Мэргэжлийн яамныхаа саналыг бүрэн дүүрэн ойлгоогүй юм уу эсхүл техникийн алдаа байдлаар мэргэжлийн бус яам өөрөө ийм салбарын юман дээр ингээд бичиж оруулж ирээд, тэгээд энийг нь анзаараагүй гэж гэдэг юм уу эсхүл энийг нь хялбарчлах гээд ЗГ үндсэндээ бол энэ төслөө хурдасгах гэж оролдсон. Тэгээд хурдасгаж байгаа нь гээд ганцхан Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцээд нөгөө бусад салбарын яамнууд нь дуу хоолойгоо гэдэг юм уу оруулж чадаагүйгээсээ болоод алдааг хууль тогтоогч засахгүйгээр цаашаа үргэлжлэх тийм эрсдэл үүсэж байгаа.*

Тийм учраас чуулган дээр энийг хэлэх саналтай байна. Мөн Эдийн засгийн байнгын хороо тогтоолын төслийг хэлэлцсэнтэй холбоотойгоор Байнгын хорооныхоо юун дээр дүгнэлт дээр бас энэтэй холбоотой асуудлыг оруулж өгөхийг хүсэж байна.

Р.Сэддорж: *Баярлалаа. Лодойсамбуу гишүүн 1 санал байгаа юм байна.*

Ч.Лодойсамбуу: *Энд ажлын албаныхны дээр үүссэн асуудал байх шиг байна. Горимын санал гаргаж байгаа юм. Гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй санал, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал дээр нэг санал давхцаад, минийх болон ажлын хэсгийн гаргасан санал утга нэг ойролцоо давхацчихсан юм байна. Тэгэхээр ажлын хэсгийн саналыг хүчингүй болгоод, ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй 4 дэх саналыг хүчингүй болгож, Их Хурлын гишүүдийн санал болгосон саналын томьёоллын 1 дэх санал хураалтыг дахин явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.*

Р.Сэддорж: *Тийм нэг заалтыг 2 өөрөөр дэмжээд санал хураачихсан байгаа юм байна. Тэгээд аль нэг рүү нь оруулахгүй бол болохгүй байгаа юм байна. Одоо энэ саяын санал хураалтаар дэмжсэн нэг санал дээр нэг заалтаар 2 юм явчхаад байгаа юм байна. Тийм учраас энийг салгаж, чуулганд оруулах шаардлагатай байгаа юм байна. Хэддүгээр заалт билээ? Энэ горимын санал дээр ажлын хэсэг дээр дэмжсэн энэ хавсралтын 1.3.9 дэх заалтыг ингээд 2 юман дээр давхцаад байгаа учраас, 2 юун дээр давхцаад байгаа учраас энэ дээр санал хураалт явуулах гээд байгаа юм. Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн. Ганхуяг гишүүний микрофоныг өгье.*

Х.Ганхуяг: *Энэ ажлын хэсэг дээр Энхтүвшин гишүүн та хоёрын санал бол яг давхацсан 2 санал гарч ирсэн. Энхтүвшин гишүүнийхийг бол ингээд бас юун дээрээ нэлээн задалж бас хэд хэдэн заалтууд оруулсан байгаа. Тийм. Тийм болохоор би энэ дээр бол Лодойсамбуу гишүүнийг энэ удаадаа саналаа татчихвал яасан юм бэ л гэдэг л ийм л санал гаргамаар байна. Тэгэхгүй энийг чинь нэг бол нийлүүлэх асуудал үүснэ. Тэгэхдээ яг л ингээд л утга нэг, бизнесийн орчныг сайжруулъя гэдэг асуудал энэ бол Энхтүвшин гишүүний хэддүгээр саналаар орлоо? 4-өөр орсон. Тийм, 4-өөр орсон. Тэгэхээрээ заавал ч үгүй ингээд*

адилхан, адилхан санал бид нар энэ чинь жилийн төлөвлөгөө шүү дээ Хөгжлийн төлөвлөгөө.

Р.Сэддорж: *Лодойсамбуу гишүүний микрофон өгье.*

Ч.Лодойсамбуу: *Энэ миний гаргасан санал энэ ажлын хэсгийн гаргасан санал 2 өгүүлбэрийг нь уншсан ч гэсэн адилхан санал ерөөсөө биш. Би бизнес эрхлэхэд учирч байгаа хууль, эрх зүйн саадыг арилгая, эрх зүйн орчныг сайжруулъя гэж байгаа болохоос биш бизнесийн орчны тэгэнгүүтээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний тухай ерөөсөө ч яриагүй. 2 өөр санал. Тэгээд энийг нэгтгээд оруулчихъя гэж байгаа бол энийг тэр техникийнх нь дагуу хийхгүй болохоор хууль, эрх зүйн орчныг сайжруулъя гэдэг саналыг нь татаад авчих гэдэг боломжгүй л санагдаад байна.*

Р.Сэддорж: *Ганхуяг гишүүн.*

Х.Ганхуяг: *Ийм байгаа юм Лодойсамбуу гишүүнээ. Бизнесийн эрхлэх орчны цогц үнэлгээг хийж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах ажиллагааг сайжруулсан хууль гэж байгаа юм. Сайжруулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж байгаа байхгүй юу. Хууль, эрх зүйн орчноо сайжруулъя гэж байгаа юм. Тэгэхээр чинь ерөөсөө утга нэг болчхоод байгаа юм л даа. Таны санал болохоор чинь юу байгаа шүү дээ. Хаана байна вэ, тийм бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг нь сайжруулна л гэж байгаа байхгүй юу. Тийм. Тэгээд энэ чинь бизнесийн орчныг нь сайжруулна гээд орчхоод байхад дахиад сайжруулна гэхээр чинь яг аль утгаараа та өөр гэж ер нь ойлгоод байгаа юм. Тийм, энэ дээр чинь бизнес эрхлэх орчны цогц үнэлгээ хийнэ гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр цогц үнэлгээ хийнэ гэдэг нь саад тотгор нь хаана байгаа юм бэ гэдгийг нь тогтооно гэсэн үг. Дараад нь сайжруулна гэж байгаа шүү дээ. Тийм.*

Р.Сэддорж: *Лодойсамбуу гишүүн.*

Ч.Лодойсамбуу: *Тэгэхээр энэ ерөөсөө ийм байгаа юм. 1 заалт дээр 2 агуулгыг л зүгээр яаж хэрхэн багтаах вэ гэдэг дээр маргалдаад байгаа учраас би 1.3.9-ийг 1.3.10 байдаг юм уу эсхүл яг хэд дээр дуусаж байгаа юм тэрнээс нь үргэлжлүүлээд тусад нь нэмэх байдлаар дахин санал хураалгаж өгөөч гэдэг горимын санал гаргая. Ингээд ажлын хэсгийн санал ч өөрөө багтах нь байна, миний санал ч ингээд багтих нь байна. Тэгээд гишүүд дэмжиж өгөхийг хүсэж байна. Яагаад гэхээр энэ үгчилж, утгачилж, утгачилж агуулгаар нь бөөрөнхийлж ингэж явахгүй л дээ, ерөнхийд нь явахгүй энэ чинь төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөө. Гэхдээ энэ дээр яг хууль, эрх зүйн саадыг арилгана гэж тусгаж байж бид нар дараа нь 3Г-таа барьж явах, шахаж шаардах үг, өгүүлбэрийг нь нарийн оруулах л шаардлагатай байгаа юм л даа. Баярлалаа, дэмжиж өгөөрэй.*

Р.Сэддорж: *Эхлээд одоо ингээд шинэ заалт оруулж ирж санал хураах гэж байна. Тэрний өмнө Лодойсамбуу гишүүний гаргасан саналыг дэмжигдсэн саналыг хүчингүй болгох санал хураалт явуулах юм байна. Тэрний дараа шинэ 1.3 дахь заалтад шинэ заалт нэмэх. 1.3.10 гэдэг заалт нэмж оруулахаар, дараа нь санал хураалт явуулна. Одоо ингээд Лодойсамбуу гишүүний дэмжигдсэн саналыг оруулсан дэмжигдсэн саналыг хүчингүй болгох санал хураалтыг горимын саналаар оруулъя. Санал хураалт. Эхлээд хүчингүй болгоно. 53,8 хувиар горимын санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй болсон.*

Лодойсамбуу гишүүний гаргасан Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын

1.3 дахь хэсэгт доор дурдсанаар шинээр заалт оруулах:

"1.3.10.Бизнес эрхлэхэд учирч буй хууль, эрх зүйн саадыг арилгаж, эрх зүйн орчныг сайжруулна." Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу. Санал хураалт. Найдалаа гишүүн горимын санал гаргах саналтай байна.

Б.Найдалаа: *Сая энэ гацаад техник асуудалтай байгаад байна дахин санал хурааж өгөхийг хүсье.*

Р.Сэддорж: *Саяын сүүлийн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Мөнхсоёл гишүүн горимын санал гаргая.*

Б.Мөнхсоёл: *Байна уу? Минийх яг энэ үнэхээрийн гацчихлаа, дахиад авахгүй бол болохгүй нь.*

Р.Сэддорж: *Мөнхсоёл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Лодойсамбуу гишүүний гаргасан саналаар дахин санал хураалт явуулъя. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.*

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дуусалаа. Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг уншиж танилцуулна.

17.13 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА